

**ОЛОН УЛСЫН ЭДИЙН
ЗАСГИЙН ХАРИЛЦАА**

II

“ЭДИЙН ЗАСГИЙН ХОРИГ: МОНГОЛ УЛСЫН СОРИЛТ, ШИЙДЭЛ”

T.Уянгаа*

Abstracts: This article talks about an economic sanctions is one of the diplomatic instruments, linkages between economic diplomacy and economic sanctions, interdependences of soft power and economic sanctions, the historic background of the USA's neutrality acts, economic sanctions against other countries, its cause, purpose and essence and Mongolian the key issues, etc.,

Keywords: economic diplomacy, instrument, sanction, embargo, veto, FTA, tariff, and black list

Дипломат ажиллагаанд улс төрийн бодлого тэргүүлэх шинжтэй боловч, эдийн засгийн чиглэл тодорхойлох шинжтэй байх нь түүхэнд олонтаа байсан бөгөөд даяаршлын эрин үед хөгжлийн асуудал тэргүүн зэрэгт тавигдаж, түүний ач холбогдол улам бүр өсөн нэмэгдэж байгаа нь бидний нүдний өмнө илт болов.

Дэлхийн II дайны дараа АНУ-ын Засгийн газар дипломат ажиллагааг «худалдаажуулах» эрчимтэй арга хэмжээ авснаар «*trade diplomacy*» гэсэн нэр томьёо гарчээ. Энэ нь эдийн засгийн дипломат ажиллагааны нэг хэсэг юм. Мөн «*commercial diplomacy*» гэсэн нэр гарсан нь цэвэр бизнес, арилжаатай холбоотойгоор Үндэстэн дамнасан корпорациудын дэлхий даяар явуулж буй олон улсын маркетингийн бодлоготой холбоотой гэж хэлж болно.

Орчин үеийн эдийн засгийн дипломат ажиллагааны үндэс суурь чухамхүү АНУ-д тавигджээ. АНУ-ын эдийн засгийн дипломат ажиллагааны үндсэн зорилго нь **иэгд**. Дэлхийн эдийн засагтай нягт холбогдсон үндэсний эдийн засгийг макро, микро түвшинд зөв менежментээр удирдах, **хоёрт**. Америкийн үндэсний эрхэм дээд эрх ашгийг удирдлага болгон глобал эдийн засгийн харилцаа, дэлхийн зах зээлийг зөв менежментээр удирдах, **гуравт**. АНУ-ын гадаад дахь худалдаа, хөрөнгө оруулалт, оюуны өмчийн эрхийг туштай хамгаалах, **дөрөвт**. Олон улсын эдийн засгийн харилцаан дахь тарифын болон тарифын бус саад тотгорыг арилгаж, худалдаа, хөрөнгө оруулалтыг хөнгөвчлөх, **五六**. Олон улсын аюулгүй байдлыг эдийн засгийн аргаар хангах, **зургаад**. Дэлхий дахинд АНУ-ын талаар зөв имиж бүрдүүлэх, **долоод**. Хүний эрх, ардчилал, сайн засаглал, зах зээлийн эдийн засгийг туштай баримтлагч, олон улсын терроризмын эсрэг тэмцэгч улс орон, Засгийн

* Т.Уянгаа. ХИС-ийн докторант, Монгол-ЕХ-ны түншлэлийг дэмжих төвийн төслийн шинжээч

газрыг бүх талаар дэмжих (жишээ нь: АНУ-ын Мянганы сорилтын сангийн буцалтгүй тусламж), **наймд**, Олон улсын энхтайван, аюулгүй байдалд заналхийлж буй болон үл ташаагч орнуудын (цөмийн болон баллистик пуужингийн хөтөлбөр хэрэгжүүлж буй, олон улсын эрхзүйн зарчим, хэм хэмжээг ноцтой зөрчсөн, хүний эрх, ардчилал, сайн засаглал сул, цэргийн дэглэмтэй, олон улсын терроризмийг зохион байгуулагч, өөгшүүлэгч, хил дамнасан зохион байгуулалтай гэмт хэрэгтэй (тухайлбал: хар тамхи, зэвсгийн хууль бус наймаа, бохир мөнгө угаах, хүний наймаа г.м.) холбогдсон орнуудын эсрэг Өрнөдийн орнуудтай хамтран эдийн засгийн *sanction, embargo*, харин НҮБ-ын АЗ-ийн хүрээнд *veto* тавих арга хэмжээг хэрэгжүүлдэг. Эдийн засгийн хориг арга хэмжээ нь аливаа улсын үндэсний аюулгүй байдал, иргэдийн амжиргаанд шууд нөлөө үзүүлдэг.

Эдийн засгийн хоригийг зорилгодоо хүрэхийн тулд их гүрнүүдээс явуулж буй гадаад бодлогын чухал арга хэрэгсэл хийгээд мөн зөөлөн хүчиний бодлого гэж үзэх нь буй. Тиймээс ч их гүрнүүдийн эдийн засгийн дипломат ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг болдог. ОХУ-ын эсрэг авсан эдийн засгийн хориг нь Крымийн хойг, Донбассын нутаг дэвсгэрийг олон улсын эрхзүйн дагуу шийдвэрлэх, Ираны эсрэг хориг нь цөмийн болон пуужингийн хөтөлбөрийг нь устгахаас гадна терроризмыг дэмжигч, өөгшүүлэгч бодлогыг нь таслан зогсоох, Венесуэлийн эсрэг хориг бол чадамжгүй болсон Николас Мадураг огцруулж, сонгогч олон түмний эрх ашигт нийцсэн шударга сонгууль явуулах, Хойд Солонгосын эсрэг авсан НҮБ-ын Аюулгүй Зөвлөлийн хориг бол Солонгосын хойгийг цөмийн болон пуужингийн хөтөлбөрөөс ангижруулах зорилготой билээ. АНУ-аас Хятадтай хийж буй худалдааны дайны зорилго, мөн чанар нь тарифын арга хэрэгслээр худалдааны тэнцвэртэй харилцааг тогтоох, оюуны өмчийн хууль бус ажиллагааг таслан зогсоох, дотоод зах зээлээ хамгаалах, үндэсний үйлдвэрлэл, компаниудаа дэмжих агуулагатай гэж тайлбарладаг.

Улс орон, байгууллага, хувь хүнийг хар жагсаалтад оруулах нь хоригийн нэг хэлбэр, эдийн засгийн дипломат ажиллагааны нэг бүрэлдэхүүн хэсэг болдог.

Эдийн засгийн дипломатын арга хэрэгсэлд **хоёр** талт яриа хэлэлцээ, хамтын ажиллагааг оруулж болох юм. Тухайлбал, Монгол Улс-Евазийн эдийн засгийн холбооны хоорондын Чөлөөт худалдааны яриа хэлэлцээ, Монгол, Японы Эдийн засгийн түншлэлийн Ерөнхий хэлэлцээр, Монгол Улс, АНУ хоорондын худалдаа, хөрөнгө оруулалтын асуудлаарх Ил тод байдлын хэлэлцээр, Монгол Улс, БНСУ-ын хооронд Чөлөөт худалдааны 1.5 дугаар сувгийн яриа хэлэлцээ, Монгол Улс, БНХАУ-ын хооронд Чөлөөт худалдааны яриа хэлэлцээ зэргийг дурдаж болно.

Олон талт яриа хэлэлцээ, хамтын хамтын ажиллагааны тухайд ДХБ-ын хүрээнд 2001 оны 11 дүгээр сард эхэлсэн ХАА-н бүтээгдэхүүний тарифын асуудлаарх Дохагийн олон талт үе шатны хэлэлцээ (Doha Round)-ний хүрээнд 2003 онд Канкун (Мексик), 2005 онд Хонг Конг, Парис, Потсдам, 2004, 2006, 2008 онд Женев, 2015 онд Найробийн олон талт үе шатны яриа хэлэлцээ, 2018 оны 12 дугаар сарын 30-наас хүчин төгөлдөр үйлчилж буй Номхон далай дамнасан

Чөлөөт худалдааны хэлэлцээр (The Comprehensive and Progressive Agreement for Trans-Pacific Partnership (CPTPP), Их 20-ийн дээд түвшний уулзалтын үеэр 2018 оны 11 дүгээр сарын 30-нд Буэнос-Айрест гарын үсэг зурсан Хойд Америкийн Чөлөөт худалдааны шинэ хэлэлцээр (USMCA), ОХУ, Монгол, БНХАУ-ын хооронд эдийн засгийн коридор байгуулах Уфа, Ташкент, Циндаогийн дээд түвшний яриа хэлэлцээ зэргийг нэрлж болно.

Эдийн засгийн дипломатын арга хэрэгслийн нэг чиглэл нь тарифийн зохицуулалт болон эдийн засгийн протекционизм байдаг. АНУ-ын Ерөнхийлөгч Д.Трамп АНУ нэгдүгээрт гэсэн үзэл баримтлалын хүрээнд БНХАУ төдийгүй холбоотнуудтайгаа тарифийн асуудлаар маргаантай яриа хэлэлцээг эхлүүлээд байгаа юм. 2018 оны 1 дүгээр сараас эхэлсэн АНУ-БНХАУ-ын хоорондын тарифын асуудлаарх худалдааны дайн бүтэн нэг жил үргэлжилж буй бөгөөд Вашингтон, Бээжин хотноо сунжирсан яриа хэлэлцээ ид явагдаж байна. Д.Трампын Засаг захиргаа Хятадтай хийж буй худалдаан дахь 500 орчим тэрбум ам. долларын алдагдлыг тарифаар зохицуулах, оюуны өмчийн хууль бус ажиллагааг таслан зогсоохыг чухалчлан хөндөж байгаа ажээ. Хятадын “Huawei Technologies Co.Ltd.” худалдааны дайны гол объект болсноор худалдааны дайн II үе шатандaa шилжиж байгаа тухай тэмдэглэх болов. АНУ-аас Хятадтай эхэлсэн худалдааны дайны мөн чанар бол чухамдаа тарифт суурилсан худалдааны шинэ хориг арга хэмжээ, «Америк нэгдүгээрт» бодлогын тод илрэл юм. АНУ-ын энэхүү бодлого хамгийн ойр холбоотнуудтай харилцах тухайд ч тодорхой харагдсаар байгаа билээ.

Эдийн засгийн дипломатын арга хэрэгсэлд худалдааны (эдийн засгийн) хориг арга хэмжээ (*sanction*) чухал байр эзэлдэг. Худалдаа, эдийн засгийн хориг арга хэмжээ нь дийлэнх тохиолдолд улс төрийн шинж чанартай байдаг бөгөөд өнөөгийн олон улсын харилцаанд үйлчилж буй эдийн засгийн хориг арга хэмжээг шинэ хүйтэн дайны гол илрэл гэж тайлбарлаж байгаа юм.

Испани хэлнээс гаралтай *embargo* хэмээх нэр томьёо нь олон улсын хууль эрхзүйн үндэстэй голдуу ачаа тээвэр, технологи, татвар, агаарын болон тэнгисийн хориг арга хэмжээ зэрэгт хэрэглэдэг байна.

Эдийн засгийн хориг арга хэмжээний түүхэн үндэс:

1930-аад онд АНУ-ын Бүгд найрамдах намын сенатч Уильям Е.Борах (William E.Borah), Артур Х.Ванденберг (Arthur H.Vandenberge), Жеральд П.Най (Gerald P.Nay), Роберт М.Ла Фоллетте (Robert M. La Follette) нар Европ, Азид болж буй цэрэг дайны ажиллагаанд шууд оролцохгүй, Дундыг (Төв) сахих бодлогын тухай хуулийг санаачлан батлуулжээ (Neutrality Acts of the United States 1930s).² Хуулийн гол агуулга нь дайнд шууд хөндлөнгөөс оролцохгүй ч буруутай талд цэрэг зэвсэгтэй холбоотой бүх төрлийн бараа материал, бусад зүйлс нийлүүлэхийг зогсоож, худалдааны хориг буюу *embargo* тавих зорилготой байв. Энэ бол АНУ-ын эдийн засгийн дипломат ажиллагааны нэг хэсэг байв.

² Neutrality Acts of the United States 1930s <https://history.state.gov/milestones/1921-1936/neutrality-acts>

АНУ-ын Ерөнхийлөгч Франклин Д.Рузвелт, Төрийн нарийн бичгийн дарга Корделл Халл (Cordell Hull) нар дээрх байр суурьд шүүмжлэлтэй хандаж байсан ч эцсийн мөчид дэмжжээ. АНУ-ын Конгресс 1935 оны 8 дугаар сард түрэмгийлэгч улсад стратегийн зориулалтай зэвсэг техник, түүний бүх эд анги, түлш, хүнс нийлүүлэхийг зогсоох тухай Дундыг (төвийг) баримтлах анхны хуулийг баталж, 1935 оны 10 дугаар сард Итали Этиопийг түрэмгийлэхэд сайхь хууль Италид үйлчилж эхэлсэн байна. 1936 оны 2 дугаар сард Дундыг сахих хоёр дахь хууль батлагдсан бөгөөд энэ нь 1936-1939 онд Испанид өрнөсөн иргэний дайнтай холбоотойгоор генерал Франциско Франкогийн дэглэмийн эсрэг худалдааны хоригийг хэрэгжүүлж, түүний эзэмшиж байсан 100 сая долларын хөрөнгө, зээлийн эрхийг нь царцаасан байна. 1937 оны 1 дүгээр сард баталсан Дундыг баримтлах гуравдахь хуульд Испаний эсрэг хоригийг чангатгажээ. 1937 оны 7 дугаар сард Япон Хятадад түрэмгийлсэн нь Алс Дорнод дахь АНУ-ын байр суурьт шууд нөлөөлсөн юм. Энэ тохиолдолд АНУ Хятадын Бүгд Найрамдах Улсыг бүх талаар дэмжиж, Японд «ёс суртхууны» хориг тавих болсон байна. Улмаар 1941 оны 8 дугаар сард Канадын хойд Ньюфаундленд арлын Аргентия хотод зохион байгуулагдсан АНУ, Английн төр, засгийн тэргүүн нарын Атлантын бага хурлын шийдвэрээр Японд нефть, нефтийн бүтээгдэхүүн, стратегийн зориулалттай түүхий эд, төмрийн хүдэр, хаягдлын нийлүүлэлтэд хориг тавьсан юм.

1937 оны 10 дугаар сарын 5-нд Чикаго хотод зохиогдсон уулзалтад Ерөнхийлөгч Франклин Д.Рузвелт хэлсэн үгэндээ: түрэмгийлэгч улсуудын эсрэг олон улсын хорио цээрийн (quarantine) дэглэм тогтоох санал дэвшүүлсэн байна. 1939 онд нацист Герман Чехословак, Польш улсуудыг түрэмгийлэв. 1939 оны 11 дүгээр сард Төвийг сахих дөрөв дэх хуулийг баталж, Их Британи, Францад тусlamж үзүүлэх агуулгатай байв. 1941 оны 3 дугаар сард АНУ-ын Конгресс *Lend Lease*-ийн хуулийг баталснаар АНУ-ын Төвийг сахих, хөндлөнгөөс үл оролцох үе шат дуусгавар болсон байна. 1941 оны 9 дүгээр сард АНУ-ын худалдааны хөлөг онгоцыг германы шумбагч завь устгасан, 1941 оны 12 дугаар сарын 7-нд Японы агаарын цэргийн хүчин АНУ-ын Хавайн арлын Сувдан эрэгт байрлах АНУ-ын Номхон далайн тэнгисийн цэргийн хүчинд гэнэтийн хүчтэй цохилт өгсний дараа АНУ 12 дугаар сарын 8-нд Тэнхлэгийн орнуудын (Япон-Герман-Итали) эсрэг албан ёсоор дайн зарласан билээ.

Хүйтэн дайн эхэлж, ЗХУ атомын зэвсэгтэй болсон нь тодорхой болсны дараа Өрнөдийн хөгжингүй орнуудын экспортод олон талт хяналт тавих Зохицуулах хороо KOKOM (Coordinating Committee fot Multilateral Export Controls-CoCom)-ыг 1949 оны 11 дүгээр сард АНУ-ын санаачилгаар «каман хэлэлцээр»-ийн зарчмаар байгуулж, үүрэг, зорилтыг нь тодорхойлжээ. Гол зорилго нь ЗХУ тэргүүтэй социалист орнуудад «стратегийн бүтээгдэхүүн» буюу өндөр технологи, техник, тоног төхөөрөмж, *know-how*, патент, лизенцийн экспортод хориг тавьж 3 төрлийн бүтээгдэхүүн-технологийн жагсаалтыг гаргаж, хяналт тавьж иржээ. КОКОМ-д Өрнөдийн аж үйлвэржсэн 17 орон, Япон орж байсан бөгөөд НАТО-гийн хүрээнд үйл

ажиллагаагаа зохицуулан явуулж байсан байна. КОКОМ-ын төв удирдлага Парист байрлаж, жилд хоёр удаа чуулж байв. 1982 онд японы «Toshiba Mashine Co., Ltd»®, «Konsberg Group» КОКОМ-ын журмыг зөрчсөн хэмээн АНУ тэргүүтэй Өрнөдийн орнууд тэдгээрийн эсрэг хориг тавьсан юм. Учир нь тэдгээр компаниудаас ЗХУ-д нийлүүлсэн технологийг атомын шумбагч байлдааны хөлөг онгоцны хөдөлгүүрт ашигласан дуулиант хэрэг гарсан юм. Эдгээр хэрэг 1987 онд намжсан билээ. Берлиний хана нурж, Варшавын гэрээ татан буугдаж, ЗХУ задарч, хүйтэн дайн төгсгөл болсны дараа КОКОМ-ын чиг үүрэг үндсээрээ өөрчлөгдсөн байна.³

1980 оны Москвагийн Олимпоос олон улсын нэр хүнд бүхий спортын уралдаан, тэмцээн хүйтэн дайнаас шалтгаалан үзэл суртлын сөргөлдөөний шинж чанартай болж, 1984 оны Лос-Анжелест болсон зуны Олимпийн тэмцээнд ЗХУ-ын хоригийг шууд аялдан дагаж социалист хамтын нөхөрлөлийн хэмээх орнууд болон социалист чиг баримтлалтай гурав дахь ертөнцийн зарим орон оролцоогүй юм. Тиймээс ч Сөүлийн Олимп олон улсын онцгой анхаарлын төвд байжээ.

1979 оны 12 дугаар сард ЗХУ Афганистанд цөмрөн орж, цэргийн хүчээр түрэмгийлэн эзэлсэн нь олон улсын харилцаанд төлөвшөөд байсан 1970-аад оны намжмал байдлыг бүхэлд нь эвдэн нурааж, тиймээс ч 1980 оны зуны Олимпийг Москвад зохион явуулах нь түвэгтэй болохыг ЗХУ-д Олон улсын олимпын хороо анхааруулсан байна. АНУ-ын Ерөнхийлөгч Жимми Картер мэдэгдэл гаргаж, түүнд 1980 оны 2 дугаар сарын 20-нд Дорнодын цагаар 00.01. ам-ээс өмнө ЗХУ-ыг Афганистанаас цэргээ нэн даруй эгүүлэн татахыг шаардаад, эс биелүүлбэл ардчилалын үнэт зүйлсийг эрхэмлэн дээдэлдэг чөлөөт ертөнцийн орнууд, түүнийг дэмжигчид Москвад зохиогдох зуны Олимпти оролцох боломжгүй болно гэсэн байна. Мэдээж, ЗХУ цэргээ гаргаагүйгээр үл барам түрэмгийллээ шатлан үргэлжлүүлж, зорилгоо Олимпийн өмнө гүйцэлдүүлэхийг шаргуй эрмэлзсээр байсан тул 3 дугаар сарын 21-нээс Өрнөдийн хориг хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлжээ. Ийнхүү Москвагийн Олимпти дэлхийн 81 улс орон ЗХУ-ын түрэмгийллийн улмаас оролцож чадаагүй юм.⁴

Дээрхтэй холбогдуулан АНУ болон Өрнөдийн орнууд ЗХУ-ын эсрэг эдийн засгийн томоохон хориг арга хэмжээг авч эхэлсэн нь ЗХУ-ын хувьд юуны өмнө үр тариа, хүнсний хангамжид ноцтой сөрөг нөлөө үзүүлжээ. Тиймээс ч үр тариагаар дотоодын хэрэгцээгээ хангах хүндхэн хөтөлбөр боловсруулах шаардлагатай тулгарсан тухайгаа М.С.Горбачев⁵ өөрийн бүтээлдээ бичсэн нь буй.

Харин 1984 оны Лос-Анжелесын Олимпти ЗХУ үндэслэлгүй хариу хориг тавьсанаар Румын, ХБНСЮУ, БНХАУ-аас бусад ЭЗХТЗ-ийн гишүүн социалист Болгар, Куба, Чехословак, БНАГУ, Унгар, Монгол, Польш, Вьетнам, ЗХУ зэрэг

³ Mastanduno, M. *Economic containment: CoCom and the politics of East-West trade*. Cornell paperbacks. Cornell University Press, Ithaca, N.Y.: 1992, pp. 210-218

⁴ Caraccioli, Tom. *Boycott: Stolen Dream of the 1980 Moscow Olympic Games*. Washington D.C.: New Chapter Press. 2008, pp. 188-191

⁵ М.С.Горбачёв. Бүх юм өөрийн цаг хугацаатай. УБ.: 2013, 225 дахь тал

9 орон, ажиглагч гишүүн БНАСАУ, Лаос болон социалист чиг баримтлалтай Афганистан, Ангол, Этиоп, мөн Зөвлөлтийн хоригоос үл хамааран Америкийг таашаадаггүй Иран, Ливи бүгд 16 улс л оролцож чадаагүй юм. Лос Анжелесын Олимпоос Румынын тамирчдын хүртсэн 53 медалийн 20 нь алт, Югославын 18 медалийн 7 нь алт, Хятадын 32 медалийн 15 нь алт байсан юм. ЗХУ сөргүүлэн 1984 оны зун Москвад коммунист 9 орны тамирчид оролцсон “Сайн санааны тогтолт” зохион байгуулж, жүжиглэсэн тогтолт хийсэн билээ.

БНАСАУ 1988 оны Сөүлийн Олимпийг Солонгосын хойгийн өмнөд, умард хэсэгт нэгэн зэрэг зохион байгуулах тухай хоосон лоозунгонож байв. Өмнөд Солонгос ч Олон Улсын Олимпын Хороотой зөвшилцөн зарим төрлийн тэмцээнийг Хойд Солонгост явуулахыг зөвшөөрсөн боловч Умардынхан хүлээж аваагүй юм.

1981 оны 9 дүгээр сарын 30-нд ХБНГУ-ын Баден-Баден хотод болсон ОУОХ-ны 84 дүгээр чуулган, Олимпын XI Конгрессоор Өмнөд Солонгосын Сөүл хот Японы Нагоя хоттой өрсөлдөн ялж, 1988 оны зуны Олимп зохион явуулах эрх олж авсан нь 1964 оны Токиогийн Олимпоос хойш Азид 2 дахь удаагаа зохиогдооор болсон нь энэ юм.

БНАСАУ, түүний хамгийн ойрын холбоотон Куба, социализмын чиг баримталсан Этиоп, Мадагаскар улсууд нь цэвэр улс төр, үзэл суртлын шалтгаанаар, Никарагуа дотоодын иргэний дайн, эдийн засгийн шалтгаанаар, Сейшеллийн арал, коммунист Албани (1976, 1980, 1984 оны Олимпод оролцоогүй) нь өндөр ур чадвартай тамирчидгүй зэрэг шалтгаанаар долоохон орноос бусад дэлхийн 160 гаруй орон Сөүлийн Олимпийн тоглолтод (БНМАУ 28 тамирчдын бүрэлдэхүүнтэй баг оролцож, боксын төрлөөр анх удаа хүрэл медаль Н.Энхбат хүртсэн билээ) амжилттай оролцсон нь Олимпийн түүхэнд хамгийн олон орон оролцсон нэр хүндтэй тогтолт болж, 11330 гаруй хэвлэл, мэдээллийн хэрэгслүүд дэлхий дахинд дамжуулсан байна.

Хойд Солонгосын үзэл сурталжсан бодлогоос шалтгаалж, Өмнөд Солонгосыг “АНУ-ын империализмийн дуулгавартай зарц, тоглоомын засаглалтай, хоцрогдсон орон” хэмээн социалист орнууд, түүний дотор БНМАУ үзэж байсан юм.

ОХУ-ын эсрэг хориг: Олон улсын энхтайван, аюулгүй байдалд ноцтой асуудал шинээр гарч байгаа нь НҮБ-ын Аюулгүй Зөвлөлийн байнгын гишүүд өөрсдөө түрэмгийлэл үйлдэж байгаа явдал болно. 2014 оны 3 дугаар сард ОХУ Крымийн хойгийг өөртөө албадан нэгтгэсэн нь олон улсын эрхзүйн зарчим болон олон улсын эрүүгийн эрхзүйн зарчим, хүйтэн дайн дууссанаас хойш Европт тогтсон олон улсын шинэ дэг журам, статусыг ноцтой зөрчсөн үйлдэл болов. АНУ, ЕХ, НАТО ОХУ-д хандан Украинтай байгуулсан 1997 оны 5 дугаар сарын 28, 2010 оны 4 үгээр сарын 22-ны хэлэлцээрээр хүлээсэн олон улсын үүргээ шударгаар биелүүлж, Крымийн хойгоос цэргээ нэн даруй эгүүлэн татахыг шаардсан юм. Энэ үед ОХУ Крымийн хойгийг өөртөө албадан нэгтгэсэн үйл явдалтай холбогдуулан Косовогийн статусын асуудлыг ч сөхөж байсан юм. Гэвч Косово бол ХБНСЮУ-ын

задрах үйл явцын нэг хэсэг байсан бөгөөд Крымийн хойгийн асуудалтай огтхон ч холбоогүй байв.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 68/262 дугаар тогтоол: Дээрх үйл явдалтай холбогдуулан 2014 оны 3 дугаар сард НҮБ-ын Аюулгүй Зөвлөл яаралтай хуралдаж, Крымийн хойгоос ОХУ-ыг цэргээ нэн даруй эгүүлэн татахыг шаардаж, Крымийн хойгийн ард нийтийн санал хураалт хууль бус гэж үзэж, улмаар хүч түрэн өөртөө албадан нэгтгэсэн (annexation) үйлдлийг буруушааж, тус бүсэд НҮБ-ын энхийг сахиулах хүчинийг оруулах тогтоолын төслийг хуралдаанаараа ширүүн маргааны дунд 7-н ч удаа авч хэлэлцэн боловч ОХУ тухай бүрт нь “хориг” тавьж, БНХАУ түдгэлзсэн санал өгч, Аюулгүйн Зөвлөлийн бусад 13 гишүүд (байнгын гишүүн АНУ, Их Британи, Франц, байнгын бус Аргентин, Австрали, БНСУ, Йордан, Литва, Люсембург, Нигерия, Руанда, Чад, Чили) дэмжиж байв. БНХАУ хэдийгээр ОХУ-ын стратегийн түнш, ойрын холбоотон боловч энэ асуудал дээр нэлээд түвэгтэй байдалд орсон гэж хэлж болно. БНХАУ Түвд, Синьцян-Уйгурын (Xinjiang Uyghur) автономит мужийн дотоод дахь салан тусгаарлах ажиллагаа зэрэг тулгамдсан эмзэг асуудлуудтай. Хэрвээ Крымийн санал асуулгыг дэмжвэл энэ нь өөрийнх нь газар нутгийн бүрэн бүтэн байдалд сөргөөр нөлөөлөх байсан нь ойлгомжтой байв.

Тиймээс дээрх асуудлыг НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулганд оруулсан юм. 2014 оны 3 дугаар сарын 27-нд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 68 дугаар чуулганы 69 дүгээр хуралдаан Крымийн хямрал, түүнтэй холбоотой “Украины газар нутгийн бүрэн бүтэн байдал”-ыг⁶ дэмжсэн 68/262 тоот тогтоолын төслийг авч хэлэлцэв. Тогтоолд Крымийн хойг нь олон улсын эрхзүйн дагуу Украина нутаг дэвсгэрийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг гэдгийг НҮБ хүлээн зөвшөөрсөн, тиймээс 2014 оны 3 дугаар сарын 16-нд Крымд явагдсан бүх нийтийн санал асуулга нь хууль бус учир хүчин төгөлдөр бус гэж үзжээ. Тогтоолыг НҮБ-ын гишүүн 193 ороос 100 орон бүрэн дэмжив. Энэ нь НҮБ-ын гишүүн улсуудын 51.81 хувь, санал өгсөн гишүүдийн 59.17 хувь, дэлхийн хүн амын 33.80 хувь болов. Харин тогтоолын төслийг 11 улс буюу Армен, Беларусь, Болив, Венесуэл, Зимбаби, Куба, Никарагуа, ОХУ, Сири, Судан, Хойд Солонгос зэрэг 11 улс эсэргүүцэв. Тогтоолыг ямар дэглэмтэй, ямар байр суурь баримталдаг улс эсэргүүцсэн нь ойлгомжтой. Тэдгээр нь НҮБ-ын гишүүн улсуудын 5.70 хувь, санал өгсөн гишүүдийн 6.51 хувь, дэлхийн хүн амын 4.49 хувь болж байна. Тогтоолд НҮБ-ын гишүүн 58 улс түтгэлзсэн санал өгчээ. Үүнд: Монгол Улс, БРИКС-ийн орнууд болох Бразил, ӨАБНУ, Хятад, Энэтхэг, Вьетнам, Казахстан, Узбекистан зэрэг улсууд оров. Эдгээр улсууд НҮБ-ын гишүүн улсуудын 30.05 хувь, санал өгсөн гишүүдийн 34.32 хувь, дэлхийн хүн амын 58.15 хувь болж байв. ОХУ-ын хамгийн ойрын холбоотон БРИКС-ийн орнууд хүртэл түдгэлзсэн санал өгсөн нь онцгой анхаарал татсан юм.

Олон улсын энхтайван, аюулгүй байдалд заналхийлэл учруулж, түрэмгийлэл үйлдэж буй улс орнуудын эсрэг НҮБ-ын Р5 буюу АЗ-ийн 5 гишүүн эдийн засгийн хориг арга хэмжээ авдаг. Мөн олон улсын худалдааны дүрэм зөрчсөн, тухайлбал,

⁶ [UN General Assembly Resolution 68/262. A/RES/68/262. 69th Plenary. 27 March 2014](#)

шинжлэх ухаан-технологи, оюуны өмчийн хууль бус худалдаатай холбоотой БНХАУ, ОХУ-ыг ДХБ-д элсүүлэх асуудалтай холбоотойгоор худалдааны хэсэгчилсэн хориг арга хэмжээ авч байсан юм.

2014 оны 3 дугаар сард ОХУ Крымийн хойгийг өөртөө албадан нэгтгэсэний дараа тус улсын эсрэг ЕХ, АНУ эдийн засгийн багц хориг арга хэмжээг 3 дугаар сарын 17-ноос авч эхлэв. Үүнд: В.Путиньг хамгийн ойр тойрон хүрээлгэч өндөр дээд албан тушаалтан, корпорациудын тэргүүн нарын эсрэг визийн хориг, гадаад дахь банкны данснуудыг нь битүүмжлэх хориг арга хэмжээг эхний ээлжинд авч хэрэгжүүлэв. Эдийн засгийн хоригт Исланд, Норвеги, Албани, Монтенегро нэгдэв. 2014 оны 7 дугаар сарын 30-нд АНУ-ын Төрийн Департаментын хэвлэлийн төлөөлөгч Марие Харф, Вашингтоны Москвагийн эсрэг авч байгаа хориг арга хэмжээ нь ОХУ-ын эдийн засгийн байдлыг эрчимтэй сулруулан үүгээрээ хүн амынх нь дургүйцлийг Засгийн газрынхаа эсрэг гаргахад чиглэгдсэн гэдгийг хүлээн зөвшөөрсөн байна. Гол зорилго нь тэднийг эдийн засгийн талаас нь “хавчин” В.Путиньг зөв шийдвэр гаргах хүртэл шахалтаа нэмэгдүүлэх явдал хэмээн тэрбээр хэлжээ. Хэсэг хугацааны дараа орос иргэд түүний бус нутагт явуулж буй бодлогод болон эдийн засаг нь унаж буйд дургүйцэх болсон байх болно. Үүнийг л хориг гэж байгаа юм. Үүний төлөө л тэр хийгдэж байгаа, бид шахалтаа нэмэгдүүлсээр байх болно гэж М.Харф хэлжээ. Харин тэрбээр хориг арга хэмжээ орос хүмүүсийн эсрэг биш гэдгийг онцолсон байна. Мөн тэрбээр хэлэхдээ энэ бүгд нь шинэ хүйтэн дайн биш, үзэл бодлын сөргөлдөөн хэдэн арван жилийн турш байсан гэжээ. Хэрэв Орос Украянд түрэмгийлээгүй бол ийм зүйл гарахгүй байсан гэж тэрбээр нэмж хэлсэн байна.

2015 оны 4 дүгээр сарын 28-нд ЕХ Оросын эсрэг эдийн засгийн 2 дахь хориг арга хэмжээг хэрэгжүүлж, өнөөдрийг хүртэл үргэлжилж байна. Харин ОХУ-ын Засгийн газар 2014 оны 8 дугаар сарын 1-нээс ЕХ, АНУ, Канад, Норвеги, Австралийн эсрэг хүнсий 11 багц бүтээгдэхүүнд (мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, жимс, жимсгэнэ, хүнсний ногоо) хариу хориг арга хэмжээ авсан байна. Европын Холбоо 2014 оны 9 дүгээр сарын 12-нд ОХУ-ын эсрэг нэмэлт хориггоо зарлажээ. Хэрэв өмнө нь ЕХ-ны хөрөнгийн зах зээлд Сбербанк, ВТБ, Газпромбанк, Россельхозбанк зэрэг Оросын төрийн банкууд мөн нефтийн гурван том компанийг ороход хориг тавьсан байсан бол гуравдахь үе шатны багц хоригт “Оборонпром”, ОАК, Уралвагонзавод, “Роснефть”, “Транснефть”, “Газпром нефть” компаниуд хамрагджээ. ЕХ-ны хөрөнгө оруулагчид болон хувь хүмүүс Оросын компаниудад 30 хоногоос илүү хугацаатай зээл олгох боломжгүй болсон байна. Өмнөх хоригт үнэт цаас хамаарсан байснаас биш зээлийн асуудал ороогүй байжээ. Нефтийн салбарт бол Арктикийн бүсийн далайн ёроолоос нефть олборлох болон энэ төрлийн зориулалтын тоног төхөөрөмж нийлүүлэхийг европчуудад хориглож байна. Мөн занарын хийн олборлолтын төслүүдийн хөрөнгө оруулалт болон тоног төхөөрөмжийн нийлүүлэлтэд хориг үйлчилж эхлэв. Харин ЕХ өөрөө Оросын байгалийн хийнээс 30 хувийн хамааралтай учир хийн салбарт хориг

тавиагүй юм. Европын Холбоо холбооны нутаг дэвсгэрт нэвтрэхийг хориглосон хүний жагсаалтдаа дахин шинээр 24 хүнийг нэмжээ. Эдгээр хүмүүсийн данс ЕХ-нд байгаа бол битүүмжлэгдэнэ гэсэн байна. Ийнхүү хоригт хамрагдсан хувь хүний жагсаалтад 119 хүний нэр, мөн 23 компани хамрагдсан байна. Мөн Донбассын сайн дурынхантай худалдаа, наймаагаар холбоотой хуулийн этгээд болон хувь хүмүүсийн эсрэг хориг арга хэмжээ авах хуулийг ЕХ батлав.

Оросын батлан хамгаалах салбарын эсрэг, давхар зориулалтын бүтээгдэхүүний нийлүүлэлтэд тавьж буй хоригтоо цэргийн үйлдвэрийн бүтээгдэхүүн гаргадаг 9 холимог компанийг хамруулжээ. “Калашников концерн”, ОАО “Тулийн зэвсгийн завод”, цэргийн болон иргэний зориулалтын цахим дурангийн төхөөрөмж үйлдвэрлэдэг АО “Сириус”, механик инженерийн “Станкоинструмент” нэгдэл, “Химкомпозит” цэргийн бүтээгдэхүүн, сум хэрэгсэл үйлдвэрлэгч, цэргийн техник үйлдвэрлэгч “Технологии машиностроения” (“Техмаш”), ОАО “Высокоточные комплексы”, “Алмаз-Антей”, “Базальт”, “Сбербанк”, “Ростех” зэрэг В.Путинд хамгийн ойр компаниуд уг хоригт хамрагдсан байна. Гэхдээ Украины хямралыг зогсооход ОХУ үнэнхүү хүчин зүтгэл гаргаж байгаа гэж үзвэл хориг арга хэмжээг хэсэгчлэн эсвэл бүтнээр цуцлана гэдгээ ЕХ мэдэгдсэн юм.

Эхлээд Холбоо хориг үр дагаварын талаар 10 дугаар сарын сүүлчээр дүгнэлтээ хийгээд дараа нь түүнд өөрчлөлт оруулах эсвэл зогсоо шийдвэрээ гаргах ажээ. АНУ ч үүнтэй адил байр суурьтай байгаа юм. Гэхдээ Минскийн тохиролцоог Орос сахих юм бол хоригийг цуцлана гэдгээ Барак Обама хэлж байв. Эдүгээ Орос-Өрнөдийн орнуудын хооронд худалдааны дайн үргэлжлэн явагдсаар байгаа билээ. Ямар ч байсан Өрнөдийн эдийн засгийн хориг арга хэмжээ, өөрсдийнх нь хариу хориг, газрын тосны үнийн уналт ОХУ-ын эдийн засагт ноцтой сөрөг нөлөө үзүүлснээр эдийн засгийн өсөлт 2015 онд ДНБ -2.2 хувьд хүртэл агшсан юм. Рублийн ханшийн уналт, хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт, оросын ард иргэдэд нэн хүнд туссаар байсан боловч, 2016 оноос ХАА-н салбар, газрын тос, хий, зэвсгийн үйлдвэрт өсөлт гарч эхэлсэн байна.

Эдүгээ хоригт В.Путиныг хамгийн ойр тойрон хүрээлэгч бизнесийн магнат, тэрбумтан болон өндер албан тушаалтнууд 1000 гаруй хувь хүн, 400 гаруй байгууллага, пүүс компаниуд багтаж байгаа ажээ. ОХУ Д.Трампыг АНУ-ын Ерөнхийлөгчөөр сонгогдвол Орос, Америкийн харилцаа сайжирч, худалдааны хориг суларна хэмээн найдаж сонгуулийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцсон хэмээн дуулиан дэгдсэн билээ.

АНУ Украины хямралаас гадна 2016 оны АНУ-ын ерөнхийлөгчийн сонгуульд ОХУ “хөндлөнгөөс оролцсон”-той холбоотойгоор эдийн засгийн нэмэлт хориг арга хэмжээг 2018 оны 12 дугаар сард Ерөнхийлөгч Барак Обама авч эхэлсэн байх бөгөөд Д.Трампын Засаг захиргаа 2017 оны 8 дугаар сар, 2018 оны 3 дугаар сард авсан хориг арга хэмжээнд хөнгөн цагааны магнат Олег Дерипаский, В.Путины хүргэн байсан Кирил Шамалов, Рено групп, Газпром зэрэг олон компани, хувь хүн, судалгааны хүрээлэн хамрагдсан байна. Хамгийн сүүлд АНУ 2019 оны 3

дугаар сард Керчийн хоолойд болсон мөргөлдөөнтэй холбоотойгоор Оросын хөлөг онгоцны томоохон үйлдвэрүүдийн эсрэг шинэ хориг арга хэмжээ авсан юм.

Түүнчлэн АНУ, Өрнөдийн орнууд Крымийн гүүрний барилгын ажил эхэлсэн, Сергей Скрипал, түүний охиныг “Новичок А-234” хэмээх олон улсын хэмжээнд хориотой химийн бодисоор хордуулсан хэрэгт холбогдуулан нэмэлт хориг тавьсан байдаг. Гэхдээ Оросын иргэд өлсөж сурсан ард түмэн гэдгийг Өрнөдийнхөн хэээ ч ойлгохгүй гэж Владимир В.Жириновский хэлсэн байdag.

АНУ-ын Сангийн яам урьд нь Магнитский⁷ хуулийн (Magnitsky Act) хүрээнд ОХУ-ын таван иргэнийг хоригийн жагсаалтад оруулжээ. Уг жагсаалтад Руслан Геремеев, Геннадий Карлов, Сергей Коссиев, Елена Трикуля, “Тerek” тусгай отряд, түүний командлагч Абузайд Висмурадов нарыг оруулжээ. Руслан Геремеев бол “Север” батальоны командлагч асан бөгөөд түүнийг улстөрч агсан Борис Немцовыг хөнөөсөн хэргийн захиалагч гэж Немцовын гэр бүлийн өмгөөлөгчид үздэг бол С.Коссиев нь Карель дахь засан хүмүүжүүлэх төвийн даргаар ажиллаж байжээ. Тэрбээр албан тушаалаа урвуулан ашигласан хэргээр 2.5 жил хорих ял авсан байна. Хэвлэлүүдийн мэдээллээр, Геннадий Карлов ОХУ-ын Дотоод хэргийн яамны дэргэдэх Мөрдөн байцаах хороонд ажиллаж байсан бөгөөд “Магнитскийн хэрэг”-т холбоотой, Елена Трикуля Мөрдөн байцаах хороонд ажиллаж байжээ. АНУ-ын хууль тогтоох байгууллага Магнитскийн хуулийг 2012 оны 12 дугаар сард баталсан билээ. Уг хууль нь ОХУ-д хүний эрх зөрчигдөж байгаагийн эсрэг, тодруулбал, хүний эрхийг зөрчсөн ОХУ-ын албан тушаалтнуудын эсрэг хориг арга хэмжээ авахад чиглэсэн хууль юм.

АНУ-ын шинэ хориг арга хэмжээний хариуд зохих арга хэмжээг авна гэж Вашингтон хот дахь ОХУ-ын Элчин сайдын яамны мэдэгдэлд дурджээ. Мэдэгдэлд дурдсанаар, ОХУ-ын эсрэг шинээр хориг арга хэмжээ авсан нь “олон улсын хууль, эрх зүйтэй зөрчилдсөн албадах арга хэмжээ авах гэсэн оролдлого бөгөөд иймэрхүү арга хэмжээ нь улс орнуудын соёлжсон харилцаанд хулээн зөвшөөрөгдөшгүй гэдгийг сануулан дурдаж байна”. “Иймэрхүү алхмууд нь хариу арга хэмжээ авах шалтгаан болж байна. Хариу арга хэмжээ бол бидний сонголт биш гэдгийг үргэлж онцлон тэмдэглэсээр ирсэн билээ. Бид АНУ-тай удаан хугацаанд хамтран ажиллахыг зорьж байна. Бид үүнд бэлэн байгаа бөгөөд үүнийг зөв хувилбар гэж үзэж байна” гэж ОХУ-ын Элчин сайдын яамны мэдэгдэлд онцолжээ.

Шинэ хориг арга хэмжээ нь АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Майк Помпеогийн ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин болон тус улсын Гадаад хэргийн сайд Сергей Лавровтой Сочи хотноо хийсэн уулзалтын дараа манай хоёр улсын харилцаанд үүсэн бий болсон нааштай уур амьсгалтай зөрчилдөж байна гэж мэдэгдэлд цохон тэмдэглэсэн байна.

⁷ Сергей Магнитский (1972-2009) ОХУ-ын татварын мэргэжилтэн, аудитор, хүний эрхийн идэвхтэн. Түүний ажиллаж байсан Firestone Duncan консалтинг компани ОХУ-ын төсвийн мөнгөнөөс 5.4 тэрбум рублийг (\$230 сая ам. долл) шамшигдуулсан зөрчлийг илрүүлсэн юм. Гэвч тус байгууллагын ажилтан С.Магнитскийг татвараас зугтаасан хэмээн эрүүгийн хэрэг үүсгэж тэрбээр мөрдөн байцаалтын явцад 11 сарын дараа нас баржээ.

АНУ ОХУ-aac С400 зенитийн пуужингийн системийг худалдан авах саналаа илэрхийсэн Турк, Саудын Араб, Энэтхэг, Египет, БНСВУ, Катар, Алжир, Марокко, Ирак, Иран зэрэг орнуудын эсрэг хориг арга хэмжээ авна хэмээн шахалт үзүүлсээр байгаа юм.⁸ ОХУ-ын С-400 бол алсын тусгалтай шинэ үеийн зенитийн пуужингийн цогцолбор бөгөөд байлдааны нисэх онгоц, дунд тусгалын далавчit болон баллистик пуужинг устгах зориулалттай бөгөөд 600 хүртэл км зайд байг амдан сөнөөдөг, 400 км зайд болон 35 км өндөрт байгаа байг устгах чадалтай ажээ.

2019 оны 5 дугаар сарын 13-нд “Умардын урсгал-2” зэрэг ОХУ-ын дамжуулах хоолойг далайгаар тавих төслүүдэд оролцож буй компаниудын эсрэг хориг арга хэмжээ авах тухай хуулийн төслийг АНУ-ын сенатчид боловсруулжээ. Ийм төслийг Техас муж улсаас Сенатын танхимд сонгогдсон, Бүгд Найрамдах намын гишүүн Тед Круз, Нью-Хэмпшир муж улсаас Сенатад сонгогдсон, Ардчилсан намын гишүүн Жин Шахин нар боловсруулсан тухай “Foreign Policy” сэтгүүл мэдээлсэн байна.⁹ “Умардын урсгал-2” төслийг хэрэгжүүлэхэд хөлөг онгоцоо худалдаж байгаа эсвэл түрээслүүлж буй хүмүүсийг АНУ-ын нутаг дэвсгэрт зорчихыг хориглох, тус улс дахь хөрөнгийг нь битүүмжлэхийг Сенатын гишүүд санал болгож байгаа аж. Үүнээс гадна, санхүүгийн эсвэл техникийн дэмжлэг үзүүлж буй, мөн ийм хөлөг онгоцуудын даатгалыг хариуцаж буй компаниудад хориг тогтооно. Америкийн хууль тогтоогчид Швейцарийн гүйцэтгэгч компани болох “Allseas”, “Умардын урсгал-2” төсөлд зориулж хоолой тавьж байгаа Италийн “Saipem” гэсэн барилгын хоёр компанийн үйл ажиллагаанд онцгой анхаарал хандулахаар төлөвлөжээ. ОХУ-aac Европ руу хий дамжуулах шинэ хоолой тавихыг АНУ эрс эсэргүүцэж байгаа юм. “Умардын урсгал-2” төсөл болон эл төслийг хэрэгжүүлэхэд оролцож буй Европын компаниудын эсрэг хориг арга хэмжээ авна гэж Вашингтон нэг бус удаа мэдэгдсэн билээ.

Хамгийн сүүлд Д.Трампын Засаг захиргаа Оросын хоёр компани болон цэргийн сургалтын төвд хориг арга хэмжээ авчээ. Сири, Иран, БНАСАУ-д үй олноор нь хөнөөх зэвсэг үл дэлгэрүүлэх тухай АНУ-ын үндэсний хууль тогтоомжийг зөрчсөн хэрэгт тэднийг буруутгасан юм. Баримт бичигт зааснаар, хориг арга хэмжээг авч хэрэгжүүлэх тухай шийдвэр 5 дугаар сарын 14-нд хүчин төгөлдөр болжээ. Хар жагсаалтад Хятадын хэд хэдэн хуулийн этгээд, мөн Оросын Гатчина хот дахь зенитийн пуужингийн цэргийн сургалтын төв, Тулийн багаж үйлдвэрлэлийн товчоо, “Авангард” машин үйлдвэрлэлийн газар болон тэдгээрийн салбар хэлтсүүдийг оруулсан байна. Түүнчлэн Сири дэх хэд хэдэн байгууллага, тэр дундаа Сирийн агаарын цэргийн хүчин болон шинжлэх ухааны судалгаа шинжилгээний төвүүдийн нэгд хориг арга хэмжээ авсан байна. Хориг арга хэмжээ 2 жил үргэлжлэх хэдий ч АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Майкл Помпеогийн шийдвэрээр зогсоож

⁸ The US keeps warning Turkey that buying Russia’s S-400 missile system means it can’t have the F-35, but Turkey keeps doubling down. Apr. 10, 2019
<https://www.businessinsider.com/us-congressional-committee-leaders-warn-turkey-on-f-35-s-400-2019-4>

⁹ Foreign Policy site. U.S. Senate Threatens Sanctions Over Russian Pipeline. May 13, 2019
<https://foreignpolicy.com/2019/05/13/us-senate-threatens-sanctions-over-russian-pipeline-nord-stream-two-geopolitics-energy-germany-europe-gazprom/>

болов ажээ.¹⁰

Бүс нутгийн болон олон улсын энхтайван, аюулгүй байдалд заналхийлж байсан болон заналхийлж байгаа улс орнуудын эсрэг НҮБ-ын Аюулгүй Зөвлөл болон Өрнөдийн орнууд эдийн засгийн хориг арга хэмжээг дэс дараатай авсаар ирсэн юм. Үүнд:

Родези (Зимбаби): НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл (АЗ) нийтийг хамруулсан хориг арга хэмжээг тухайлсан нэг орны хувьд анх удаа авсан тохиолдол нь 1966 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн АЗ-ийн тогтоол болсон юм. Хориг арга хэмжээг Родезийн (1980 оноос Зимбабве) эсрэг авсан юм. Родезийн Засгийн газар арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах хүчтэй бодлого явуулж, хар арьстан босогчидтой дайтаж байв. Гэхдээ АЗ-ийн тогтоолд заасан худалдааны хориг нь үнэн хэрэгтээ хэрэгжээгүй ба тус орон хөрш ӨАБНУ ба Мозамбиктай худалдаа хийж байв. Гэвч олон улсын хориг арга хэмжээ нь 1970-аад онд эрх баригчдыг босогчидтой хэлэлцээр хийлгэхэд хүргэжээ. Роберт Мугабегийн толгойлсон Зимбабвегийн Африкийн Үндэсний Холбоо засагт гарсны дараа 1979 оны 12 дугаар сарын 21-нд хориг цуцлагдсан байна.

ӨАБНУ: НҮБ-ын АЗ 1977 оны 11 дүгээр сарын 4-нд Өмнөд Африкийн зэвсгийн экспортод хориг тавьжээ. Тэр үед тус улсад апертеидын дэглэм тогтсон юм. НҮБ-ын тогтоолд тус улсын цэргийн хүчин чадал нэмэгдэж байгаа нь хөрш орнуудад аюул учруулж байна гэж тэмдэглэжээ. Энэ хориг ӨАБНУ-д өөрийн цөмийн зэвсгийг бүтээх хөтөлбөрөө эхлүүлж, армия шинэчлэхэд нь төдийлөн саад болоогүй ажээ. Харин 1980 оны дунд үед Өмнөд Африкийн эсрэг АНУ ба Өрнөд Европын авсан нэг талын хориг арга хэмжээ нь ноцтойгоор нөлөөлсөн юм. Дээрх арга хэмжээнд тус орноос түүхий эд болон алтан зоос импортлох болон тэдний санхүүгийн байгууллагуудын мөнгө хөрөнгийн ажиллагааг хязгаарлах зэрэг хамрагдсан байна. Дэлхийн эдийн засгийн Петерсоны хүрээлэнгийн үнэлгээгээр НҮБ-ын зэвсгийн болон эдийн засгийн нэг талын хоригийн ӨАБНУ-д үзүүлсэн хохирол нь нэг тэрбум доллар болсон байна. Энэ арга хэмжээ нь ӨАБНУ-ыг апертеидын дэглэмээ өөрчлөхөд хүргэсэн байна. Цаашлаад анхны бүх нийтийн сонгуулиар Африкийн Үндэсний Конгресс нам ялж, Нельсон Мандела Ерөнхийлөгчөөр сонгогдсны дараа 1994 онд хориг цуцлагджээ.

Ирак: Иракийн цэрэг Кувейтыг эзэлсэн 1990 оны 8 дугаар сарын 2-ны дараа НҮБ-ын АЗ тогтоол баталж, Багдадын эсрэг эдийн засгийн хориг арга хэмжээг авсан юм. Тогтоолоор, Иракийн импортын бараанд хориг тавьсан байна. Нефть ч хоригт хамрагдav. Тус улсад хүмүүнлэгийн бараанаас бусад тусlamжийг зогсоосон юм. Персийн булангийн дайнд Ирак 1991 онд ялагдсан ч гэсэн хориг цуцлагдаагүй. 1995 онд НҮБ нь “нефтийг хүнсээр солих” хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлснээр Ирак дэлхийн нефтийн зах зээлд эргэн орсон билээ. Гэхдээ нефтийн орлого нь

¹⁰ U.S. Sanctions Russian Arms Makers Over Alleged Iran, N. Korea and Syria Dealings.
<https://www.themoscowtimes.com/2019/05/22/us-sanctions-russian-arms-makers-over-alleged-iran-n-korea-and-syria-dealings-a65685>

зөвхөн хүнс ба эм худалдан авахад зориулагдаж байв. Хүний хөгжлийн индексээр 1990-1999 онд Ирак 55-аас 125-рт ортлоо доошилж, дундаж наслалт, бичиг үсэг тайлгадсан түвшин нь эрс буурчээ. НҮБ-ын хориг арга хэмжээгээр цахилгааны сүлжээг засах нь хориотой байснаас цахилгааны хязгаарлалт ихээхэн нэмэгдсэн байна. 1990 онд Иракийн ДНБ-ий үйлдвэрлэл 25 тэрбум ам. доллар байснаа 1992 онд нефтийн үйлдвэрлэл гурав дахин буурч, ажилгүйдэл 50 хувьд хүрсэн байна. Иракт олон улсын эвслийн хүчин орсон 2003 онд хориг цуцлагджээ.

Мьянмар: Мьянмарын эсрэг анхны эдийн засгийн хориг арга хэмжээг Европын Холбоо (ЕХ) тус оронд цэргийн дэглэм тогтсон 1990 онд авчээ. Хязгаарлалтад зэвсгийн наймаа болон эдийн засгийн тусламж үзүүлэхийг хориглосон байна. 1996 онд ЕХ тус улсын зарим албан тушаалтанд виз олголт, хөрөнгийг нь битүүмжлэх зэргээр шинэ хориг тавив. Мөн 2003 онд Мьянмарт үнэт чулуу, мод, металл импортлоход хориг тавьсан байна. ЕХ-ны хориг сөрөг хүчний лидер Аун Сан Су Жигийн гэрийн хориог үргэлжлүүлэх болсон 2009 онд чангарч, түүндээ хууль, эрхзүйн салбарын албан тушаалтуудыг оруулжээ. ЕХ-ны хориг нь Бирмийн 800 гаруй үйлдвэрийг хамарсан байна. Технологийн хөгжил сул, аж үйлдвэр түүний дотор батлан хамгаалахын үйлдвэрүүд хөгжөөгүй байсан учраас дээрх хориг Мьянмарын цэргийн хүчинд ноцтой хохирол авчирчээ. Эдгээр арга хэмжээ нь гадаадын хөрөнгө оруулалтыг бууруулан Бирмийн удирдлагыг сөрөг хүчинд үзүүлэх шахалтаа сулруулахад хургэжээ. Хоригийн улмаас 2010 он гэхэд импортыг нь 300 сая еврогоос 170 сая хүртэл унагасан байна. Гэхдээ ЕХ-ны хориг экспортод нь төдийлөн нөлөөлөөгүй ажээ. Учир нь Мьянмарын гол түвш нь 1990-2008 онд Хятад, Тайланд, Сингапур, Өмнөд Солонгос байсан ба тэдэнд экспортын нь 78 хувь ногдож байжээ. Брюссель зэвсгийн нийлүүлэлтээс бусад эдийн засаг ба худалдааны хоригоо зогсоож буйгаа 2012 оны 4 дүгээр сарын 23-нд зарласан байна.¹¹

Куба: Куба улс нь АНУ-ын эдийн засгийн бүслэн хаалтад тавь гаруй жилийн турш байгаа билээ. Анхны хориг арга хэмжээ нь тус аралд АНУ-ын хөрөнгө ба иргэний хөрөнгийг нь нийгэмчилсэн 1960 онд тавигдсан байна. АНУ 1962 оны 2 дугаар сарын 3-наас Кубатай худалдаа хийх бүрэн хориг арга хэмжээг хэрэгжүүлж өнөөг хүрч байна. Гучаад жилийн турш Кубын эдийн засгийн амьдрал нь социалист орнуудын хамтын ажиллагаагаар тэжээгдэж ирсэн ба ЗХУ гол үүрэгтэй байв. Тиймээс 1989 оны байдлаар Куба ЗХУ-д 13 тэрбум шилжих рублейн өргтэй болсон байна. ЗХУ задарсны дараа Кубад эдийн засгийн өмнө байгаагүй их хямрал үүссэн юм. ДНБ-ий үйлдвэрлэл нь 1991-1993 онд 36 хувиар унав. Эрх чөлөөний аралд хүнс болон өргөн хэрэглээний барааны хомсдол үүсэв. Энэ нөхцөлд Вашингтон эдийн засгийн бүслэн хаалтаяа чангатгахаар шийдэж, Хаванатай хамтран ажилладаг компаниудыг хоригт хамруулжээ. Кубад бараа зөөдөг хөлөг онгоцнуудыг АНУ-ын боомтуудад орохыг хориглосон байна. Кубад хөрөнгийн тусламж үзүүлдэг

¹¹ N. Anguelov. Economic Sanctions vs. Soft Power: Lessons from North Korea, Myanmar, and the Middle East Palgrave Macmillan; 2015 pp. 98-99

олон улсын байгууллагуудад мөнгө хуваарилахгүй болов. АНУ 2000 онд хоригоо бага зэрэг сулруулан тус улсад ХАА-н бүтээгдэхүүн, эм тариа нийлүүлэхийг компаниуддаа зөвшөөрсөн байна. Төлбөрийг нь бэлнээр буюу урьдчилан хийх нөхцөлтэйгээр зөвшөөрлийг өгчээ. Гэхдээ Кубын барааг АНУ-д худалдах нь хориотой хэвээр байсан юм. 2013 оны намар НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулган дээр Кубын Гадаад хэргийн сайд Бруно Родригес үг хэлэхдээ, АНУ-ын зүгээс авсан хориг арга хэмжээний хагас зуун жилд Куба улс 1 их наяд долларын хохирол амссан гэсэн байна. Гэгээн Ширээт улсын идэвхтэй зуучлалаар 2014 оны 12 дугаар сараас АНУ, Кубын харилцаа сэргэх хандлагатай болж, дипломат харилцаагаа ЭСЯ-ны хэмжээнд сэргээж, АНУ Кубыг алтан хядагч орнуудын жагсаалтаас хасч, 2015 оны сүүлч гэхэд худалдааны хоригоо үе шаттайгаар цуцалсан юм. Тийнхүү хоёр орны түүхэнд Барак Обама АНУ-ын ерөнхийлөгчийн хувиар 2016 оны 3 дугаар сард анх удаа төрийн айлчлал хийсэн билээ. Гэвч Венесуэльд өрнөж буй үйл явдалтай холбоотойгоор Кубын эсрэг зарим хоригийг д.Трампын Засаг захиргаа хэрэгжүүлж эхлээд байна.

Югослав: НҮБ-ын АЗ 1992 оны 5 дугаар сарын 30-ны тогтоолоор Боснийн дайнд арми нь оролцсон хэмээн Югославын эсрэг хориг арга хэмжээг авчээ. Үүнээс долоо хоногийн өмнө Югослав цэргээ хөршийнхөө нутгаас татсан байсан ч хориг тавигдсан билээ. Хоригийн дараа Югославын эдийн засаг ноцтой савалж гипер инфляци (hyperinflation)-д хүрч, үнийн өсөлт нь 1 их наядад хүрчээ. Тиймээс ч 1993 онд Югославын үндэсний мөнгөн дэвсгэрт динарын 500 тэрбумтын цаасан дэвсгэрт хэвлэгдэж байжээ. Эдийн засгийн хориг арга хэмжээ нь Югославын Ерөнхийлөгч Слободан Милошевич ба эрх баригч Социалист намын нэр хүндийг өсгөн, нам нь 1992 оны 12 дугаар сарын 20-ны сонгуульд ялалт байгуулахад тус болжээ. Хоригийн гол үр дүн нь тус улсын хүн амын амьжиргааны түвшинг унагаж, эрүүл мэндийн болон нийгмийн хангамжийг эрс унагасан явдал болсон юм. Мөн иргэдийн цагаачлал ч эрс нэмэгдсэн байна. Тэр үеийн санал асуулгаар 10 хүний ес нь Югославыг олон улсын спортын тэмцээн, арга хэмжээнд оролцож чадахгүй боллоо гэж харамсан өгүүлсэн байdag. Хоригийн дэглэмийг 1994 онд хэсэгчлэн цуцалсан юм. Босни, Херцоговинад иргэний дайныг төгсгөсөн Дейтоны гэрээ байгуулагдсаны дараа 1995 онд хоригийн дэглэмийг зогсоож, 2001 онд зэвсэг нийлүүлэлтэд тавьсан хоригийг цуцалсан НҮБ-ын АЗ-ийн тогтоолын дараа хориг бүрэн тавигджээ.¹²

БНАСАУ: НҮБ-ын Аюулгүй Зөвлөл 1993-2017 оны хооронд БНАСАУ-ын эсрэг 13 удаагийн хориг арга хэмжээ авчээ. БНАСАУ “Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх гэрээнээс гарч, Олон улсын атомын эрчим хүчний агентлагтай хамтран ажиллахаас татгалзсан учир 1993 оны 3 дугаар сарын 11-нд НҮБ-ын Аюулгүй Зөвлөл 825 дугаар тогтоолыг баталж байжээ.¹³ Хойд Солонгос 2006 оны 10 дугаар сарын 14-нд цөмийн бөмбөгийн анхныхаа туршилтыг хийсний дараа НҮБ-ын

¹² Ж.Бор. Д.Уламбаяр. Монголын дипломатын нэвтэрхий толь бичиг. С-Я Гутгаар боть. УБ., 2016, 456-457 дахь тал

¹³ United Nations Security Council resolution S/RES825 March 11, 1993

Аюулгүйн Зөвлөл БНАСАУ-д түүний цөмийн болон пуужингийн хөтөлбөрийг устгахад чиглэгдсэн хориг арга хэмжээг авч эхэлжээ. Хязгаарлалтаар цэргийн ямар нэгэн технологи, зэвсгийг нийлүүлэхийг хориглосон юм. Пёньян 2009 оны 6 дугаар сарын 12-нд цөмийн шинэ туршилт хийсний дараа НҮБ-ын АЗ 2009 оны 6 дугаар сарын 12-нд тогтоол гаргаж, тус оронтой хөнгөн буудлагын зэвсгээс бусад зэвсгийн бүх төрлийн худалдаа хийхийг хориглов. Мөн цөмийн болон пуужингийн үйлдвэрлэлд нь ашиглаж болох Хойд Солонгосын санхүүгийн хөрөнгийг хязгаарлах арга хэмжээг авчээ. Пёньян 2012 оны 12 дугаар сард хиймэл дагуулыг тойрог замд гаргасан пуужин зөөгч “Ийнха-3”-ыг хөөргөсний дараа НҮБ-ын АЗ хориг арга хэмжээгээ чангатгасан шинэ тогтоол гаргажээ. Хоригийн жагсаалтад пуужинг бүтээхэд оролцсон хувь хүмүүс, байгууллагууд хамрагдсан байна. Түүнд БНАСАУ-ын Аэросансрын технологийн Хороо байв. 2013 оны 2 дугаар сард БНАСАУ цөмийн ээлжит туршилт хийсний дараа НҮБ-ын АЗ тус оронд авах хориг арга хэмжээний дэглэмийг улам чангатгасан тогтоолыг 2013 оны 3 дугаар сарын 7-нд баталсан юм. Хойд Солонгосын цөмийн хөтөлбөртэй холбоотой тус орны Шинжлэх ухааны академи, нарийн техникийн импортын корпораци хоёрын гадаад дансыг хаажээ. Түүнчлэн хууль бус наймаагаар олсон орлогоос бүрдэж, гадаадын өөр өөр хүний нэрээр, мөн өөр өөр компаний нэрээр БНХАУ, Карибын тэнгисийн орнуудын болон Лихтенштейн зэрэг орнуудын жижиг банкад хадгалагдаж байсан 3 тэрбум ам. долларыг битүүмжилсэн байна. БНАСАУ-д авсан хориг арга хэмжээ нь тус улсад хүмүүнлэгийн хямралыг өдөөсөн юм. 2011 он гэхэд зургаан сая хүмүүст хоол хүнс шаардлагатай байв. Хүнсний нийт хэрэглээнийх нь 5,3 сая тонн шаардлагаас жилдээ нэг сая тонн нь дутагдаж байсан байна. Таван нас хүртэлх хүүхдүүдийн дутуу хооллолтын улмаас үүссэн ужиг өвчин нь хүүхдийн өсөлтийг зогсоож, дунджаар нийт хүүхдийн 33 хувийг, хойд нутгаараа бол 45 хувьд хүрсэн байна.

Пёньян 2017 оны 9 дүгээр сарын 3-нд цөмийн 6 дахь удаагийн туршилт хийсэн бөгөөд бүртгэгдсэн 6.3 магнитудын чичиргээний үнэлгээ нь өмнөх 2016 оны 9 дүгээр сард хийсэн тав дахь удаагийн цөмийн туршилтаас 5-6 дахин, дөрөв дэх туршилтаас 11 дахин хүчтэй болсон талаар мэргэжилтнүүд урдчилсан байдлаар тэмдэглэж байв. БНАСАУ өөрсдөө нэрлэсэн ус төрөгчийн бөмбөг хэмээх туршилтын эхний чичиргээнээс хойш 8 минутын дараа дахин 4.6 магнитудын хүчтэй хоёр дахь чичиргээ бүртгэгджээ. Туршилтын хүч 60-120 килотон орчим буюу Хирошимад хаясан атомын бөмбөгнөөс гурав дахин хүчтэй байж магадгүй гэж үзэж байв.

Тийнхүү 2017 оны 9 дүгээр сарын 11-нд НҮБ-ын АЗ-ийн 2375 дугаар тогтоолыг санал нэгтэй баталлаа. Хойд Солонгос жилд 4.5 сая баррель нефть импортоор авдаг юм байна. Зөвхөн Хятадаас өдөрт 6 мянган баррель. Шинэ хоригоор 2.2 сая баррель буюу 50 хувиар танахаар боллоо. Нэхмэл, оёмол бүтээгдэхүүний экспортыг бүрэн хориглоо. 2016 онд 752.5 сая ам. долларын бэлэн бүтээгдэхүүн үүнээс Хятадад 2.3 тэрбум, Энэтхэг 108 сая, Орос 79 сая, Тайланд 74 сая, Пакистан 43 сая,

Филиппин 53, Африкийн Буркина Фасо 33 сая ам. долларын хувьцас экспортлосон байх жишээтэй. Гадаад дахь Хойд Солонгосын 93 мянган иргэдийн мөнгөн шилжүүлэгийг бүрэн хориглосон байна. Энэ нь ойролцоогоор 500 сая ам. доллар болж байна. Энэ бол маш том хориг. Тогтоолын анхны хувилбарыг ОХУ, Хятадын талтай зөвшилцсөний дараа өөрчилж, зарим заалтыг нь сулруулсан байна. АНУ-ын анхны санал газрын тосны импортыг 100 хувь зогсоох байв.¹⁴

АНУ-ын дангаараа хэрэгжүүлж буй хоригт Хойд Солонгостой худалдаа хийж буй улс орнуудтай АНУ худалдаа хийхгүй, банкны гадаад төлбөр тооцоонд хориг тавих, олон улсын долларын системээс гаргах арга хэмжээ авахаа мэдэгдэв.¹⁵

НҮБ-ын АЗ-ийн баталсан шинэ тогтоолыг “Санаанд багтамгүй бөгөөд түрэмгий бүх арга хэрэгслийг ашиглаж буй АНУ-ын санаачилсан уг тогтоолыг БНАСАУ эрс буруушаан няцааж байна. Хориг арга хэмжээ авах тухай энэ тогтоол нь манай улсын өөрийгөө хамгаалах хууль ёсны эрхийг хасахад чиглэсэн бузар өдөөн хатгалгын үр дагавар юм” гэж Хойд Солонгосын ГЯЯ-ны Мэдэгдэл дурдсаныг тус улсын Төв цахилгаан мэдээний агентлаг уламжласан байна. “НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн шинэ тогтоол нь БНАСАУ зөв зам сонгосныг нотлож байгаа бөгөөд бид АНУ-тай бодит тэнцвэртэй байдалд хүрэх замаар эх орныхоо тусгаар тогтоно бүрэн эрх, бүс нутгийн энх тайван, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн хүчин чармайлтаа улам нэмэгдүүлнэ” гэж дээрх мэдэгдэлд тэмдэглэсэн байна. Түүгээр зогсохгүй 8 дугаар сарын 29-нөөс хойш дахин буюу 9 дүгээр сарын 15-ны Баасан гарагийн өглөө Японы Хоккайдо арлын давуулан баллистик пуужингийн туршилтыг хийлээ.¹⁶ Пүрэв гарагт Пёньяны төв мэдээллийн агентлаг НҮБ-ын тогтоолыг дэмжсэний төлөө Японыг “живүүлж”, АНУ-ыг үнс нурам болгоно хэмээн сүрдүүлж байсан юм.

2017 оны 11 дүгээр сарын 29-нд Хойд Солонгос тив хоорондын Hwasong-15 баллистик пуужин туршсан учир 2017 оны 12 дугаар сарын 22-нд **НҮБ-ын АЗ-ын 2397 дугаар шинэ тогтоолыг** санал нэгтгэй баталсан билээ. Шинэ хоригоор газрын тосны бүтээгдэхүүний нийлүүлэлтийг 90 хувиар танахаар болов. Ингэснээр жилд нийлүүлдэг 500 мянган баррель нефтийн түлш, дөрвөн сая баррель түүхий нефтийг хязгаарлана. НҮБ-ын гишүүн бүх улсад хөдөлмөр эрхэлж буй хойд солонгосын иргэдийг 24 сарын дотор нутаг буцахаар хоригт заасан юм.

Умард Солонгосын цөмийн зэвсэг, пуужингийн өдөөн хатгалгатай нь холбогдуулан олон улсын хамтын нийгэмлэг тус улсад эрчимтэй шахалт үзүүлж байгаа билээ.

БНАСАУ 2016 оны 1 дүгээр сарын 6-нд 4 дэх удаагийн цөмийн туршилт хийж, 2 дугаар сарын 7 алсын тусгалтай баллистик пуужингийн туршилт хийсний

¹⁴ UN Security Council approves new North Korea sanctions. Sept. 11, 2017

¹⁵ Matthew Cooper. Mnuchin Threat to China Over North Korea is Empty Because Beijing Owns America’s Debt. Newsweek. Sept. 12, 2017

¹⁶ Jesse Johnson, Reiji Yoshida. North Korea responds to latest U.N. sanctions with second missile over Japan. The Japan Times. Sept. 15, 2017

хариуд 2016 оны 3 дугаар сарын 2-нд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл 2270 тогтоолоор тус улсын эсрэг шинэ хориг тавьсан юм. Энэхүү хоригийн хүрээнд Монгол Улс Умард Солонгосын хөлөг онгоцнуудад өөрийн далбаагаа ашиглуулахыг 2016 оны 8 дугаар сард цуцалсан байна.

Харьялагдах улсад нь авсан хатуу хориг арга хэмжээнээс зайлсхийхийн тулд хөлөг онгоцнууд гуравдагч орны нэрийн дор үйл ажиллагаа явуулах боломжтой байдаг. Энэ тогтолцооны дагуу Умард Солонгосын 14 хөлөг онгоц гэрээгээр Монголын далбааг ашиглан үйл ажиллагаа явуулж байжээ. Монголын Засгийн газар энэ гэрээгээ цуцаллаа гэж Америкийн “Voice of America” цахим хуудсанд мэдээлжээ.¹⁷ Монгол Улс далайд гарцгүй орон боловч Монгол Улсын нэрийн дор 400 гаруй хөлөг онгоц далай, тэнгист Монголын далбааг намируулан үйл ажиллагаа явуулдаг. НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 2270 тоот тогтоолыг хэрэгжүүлж, Умард Солонгосын талтай байгуулсан гэрээгээ цуцаллаа гэж Монгол Улс 7 дугаар сарын 8-нд НҮБ-д илгээсэн тайландаа дурджээ. Монгол Улс гэрээг цуцалж байгаагаа НҮБ-д мэдэгдсэн учраас Умард Солонгосын ямар ч хөлөг онгоц Монголын далбааг ашиглах боломжгүй болсон гэж “VOA” мэдээлсэн юм. Ингэснээр НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн 2270 тоот тогтоолыг хэрхэн дагаж мөрдөж, ямар арга хэмжээ авч байгаагаа тайлагнасан 40 орны нэг нь Монгол Улс болж байв.

Иран: Ираны цөмийн хөтөлбөртэй холбоотойгоор НҮБ-ын АЗ 2006-2010 онуудад Ираны эсрэг дөрвөн багц хоригийг (2006 оны 12 дугаар сарын 23-ны, 2007 оны оны 3 дугаар сарын 24-ний, 2008 оны 3 дугаар сарын 3-ны, 2010 оны 6 дугаар сарын 9-ний тогтоолуудын дагуу) тавьжээ. Эдгээр арга хэмжээнд нь цөмийн зэвсэг ба түүнийг тээгчийг бүтээхэд хэрэгтэй тоног төхөөрөмж, эд материалын импортыг Иранд хийхийг хориглосон байна. Мөн цөмийн салбарт нь үйл ажиллагаа явуулдаг хувь хүмүүс, банкууд ба компаниудын гадаад дансыг битүүмжилжээ. EX 2007 оноос эхлэн Ираны эсрэг хоригийн 20 багцыг хэрэгжүүлж эхэлсэн юм. Хамгийн сүүлд давхар зориулалтын технологийг болон цөмийн технологи ба эд ангийг Тегеранд худалдахгүй байхаар шийдэж, 2013 оны 3 дугаар сард хоригийн дэглэмийг чангатгасан байна. Сүүлийн хоригт нь хийн ба нефтийн бүтээгдэхүүн, алт, мөнгөн эдлэл, үнэт чулууны худалдаа орсон байна. Ираны эсрэг EX-ны гаргасан хар жагсаалтад 87 хүн, 150 байгууллага ба компани оржээ. Шинжээчдийн дүгнэснээр, нефтийн хориг арга хэмжээ нь 2011-2013 онд Тегеранд 80 тэрбум ам. долларын хохирол авчирчээ. Хориг арга хэмжээгээр гадаадад байгаа Ираны дансанд ойролцоогоор 100 тэрбум ам. доллар битүүмжлэгдсэн байна. Хориг арга хэмжээний улмаас 2013 онд Ираны нефтийн орлогын сарын дундаж нь 3,4 тэрбум (ойролцоогоор 2011 оныхоос 58 хувиар бага) ам. доллар болсон байв. Ираны нефтийн экспорт 60 хувь хүртэл буурчээ. Нефтийн хориг чангараах хүртэл хоногт 3,5 сая баррель олборлож байсан Иран 2013 онд 1,1 сая баррелийг олборлож байжээ.

НҮБ ба EX-ны зүгээс Иранд авсан эдийн засгийн хориг арга хэмжээ нь 2013

¹⁷ Voice of America.VOA, August 4, 2016, KoreajoongAngdaily.joins.com

оны 11 дүгээр сард эхэлсэн (P5+1 гэдэг нь Аюулгүйн Зөвлөлийн байнгын тав, EX болон Герман улсыг хэлж байгаа юм) НҮБ-ын АЗ-ийн P5, EX, Германы зуучлагчийн хүрээнд хийгдэж байсан Ираны цөмийн хөтөлбөрийн асуудлаарх хэлэлцээний дараа эдийн засгийн хориг 2014 оны 4 дүгээр сараас аажмаар үе шаттайгаар тавигдаж эхэлжээ. Бараг 3 жил үргэлжилсэн үе шаттай сунжиран багц хэлэлцээр амжилттай дуусч, 2015 оны 7 дугаар сарын 14-нд хэлэлцээр БНХАУ-ын Гадаад хэргийн сайд Ван Ий, БНФУ-ын Гадаад хэргийн сайд Лоран Фабиус, ХБНГУ-ын Гадаад хэргийн сайд Франк-Вальтер Штайнмайер, EX-ны Гадаад бодлого, аюулгүй байдлын Дээд төлөөлөгч Федерика Могерени, Лалын БН Иран улсын Гадаад хэргийн сайд Мохаммад Завад Зариф, ОХУ-ын Гадаад хэргийн сайд Сергей Лавров, Нэгдсэн Вант улсын Гадаад хэрэг, Хамтын нөхөрлөлийн сайд Филипп Хаммонд, АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Жон Керри нар гарын үсэг зурсан юм. Хэлэлцээрийг оролцогч орнуудын парламент соёрхон баталсны дараа Ираны эсрэг НҮБ, АНУ, EX-ны эдийн засгийн хориг бүрэн цуцлагдсан юм. Энэхүү хэлэлцээрийг Израиль улс хамгийн их эсэргүүцэж байв. Гэвч Д.Трамп ерөнхийлөгчийн сонгуулийн кампанит ажиллагааны үеэр Ираны цөмийн хөтөлбөрийн хэлэлцээр нь Барак Обамагийн Засаг захирагааны байгуулсан хамгийн муу хэлэлцээр гэж нэрлэж байв. Д.Трамп ерөнхийлөгчөөр сонгогдсны дараа АНУ 2018 оны 5 дугаар сарын 8-нд дээрх хэлэлцээрээс дангаараа гарч, мөн оны 8 дугаар сарын 1-нээс Ираны эсрэг эдийн засгийн хоригийн эхний хэсэг эхэлж, 2018 оны 11 дүгээр сараас хориг бүрэн хэрэгжиж байна. Хориг нь банкны систем, олон улсын долларын систем, газрын тос, өндөр албан тушаалтнууд болон Ирантай бизнес хийж буй гуравдагч орнуудыг хамарч байгаа юм. Энэ нь EX, БНХАУ, Энэтхэг, Япон, БНСУ, Тайвань зэрэг нилээд орны үндэсний эрх ашгийг хөндөж эхэлсэн юм.

2018 оны 11 дүгээр сарын 6-нд Ираны эсрэг АНУ-ын хоригоос түр чөлөөлөгдөх найман улсын нэрийг АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Майкл Помпео зарласан юм. БНХАУ, Энэтхэг, Итали, Грек, Япон, БНСУ, Тайвань, Турк улс үргэлжлүүлэн Иранаас газрын тос импортлох боломжтой үлдэж байсан. “Энэхүү шийдвэр нь дээрх улсуудын Иранаас авах газрын тосны импортыг аажмаар хязгаарлах, мөн газрын тосны зах зээлд савлагаа үүсэхээс сэргийлэх зорилготой” гэдгийг Майкл Помпео онцолж байв. Гэвч дээрх орнууд дахь хөнгөлт 2019 оны 5 дугаар сарын 9-ний шинэ хоригоор хүчингүй болж, энэ нь баррель газрын тосны үнийг өсгөхөд хүргэж байгаа нь Монгол Улсад ч нөлөөлж эхлэв.

Майкл Помпео “Ираны дэглэм терроризмыг санхүүжүүлж, Ойрх Дорнодод тогтвортгүй байдал үүсгэж байна. Мөнгөний энэ ургсгалыг нь зогсоохын тулд бид тус улсын эсрэг хориг хэрэгжүүлж байгаа. Иранд сонголт бий. Иран улс бусад орны адил хэвийн байвал бид бодлогоо 180 хэм ч өөрчлөх боломжтой. Харин үгүй бол Тегеран эдийн засгийн хямралтай нүүр тулах болно” гэж мэдэгдлээ. Үүнээс гадна Вашингтон “Ираны эсрэг хоригийг сэргээхдээ хуучин зүйл заалтыг илүү чангатган, жагсаалтад нэмж 200 орчим нэрсийг багтаасан” гэдгийг онцолжон байна. Хувь хүн, компани, банк санхүүгийн байгууллага, хөлөг онгоц гэсэн 700 гаруй нэрэс байсныг

900 болгон нэмжээ. Энэ нь өмнө нь байгаагүй өндөр тоонд тооцогдож байгаа юм.

АНУ-ын Сангийн сайд Стивен Мнуучини мэдэгдсэнээр “Хориг арга хэмжээ Ираныг санхүүгийн хувьд олон улсаас тусгаарлаж, эдийн засгийг нь зогсонги байдалд оруулах зорилготой. Хугацааны хувьд цаашид Иран улс терроризмыг дэмжиж, цөмийн хөтөлбөрөө зогсоох хүргэлжлэх” болсон юм.

Хамгийн сүүлд АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп Иран улсын металлын олборлолт, үйлдвэрлэлийн салбарт хориг арга хэмжээ авах тухай зарлигт лхагва гарагт гарын үсэг зуржээ. Хязгаарлалтад Ираны төмөр, ган, хөнгөн цагаан болон зэсийн үйлдвэрлэл өртжээ. Энэ хориг арга хэмжээ нь Ираны металл үйлдвэрлэгчид болон металл үйлдвэрлэлийн эзэд төдийгүй Иранаас металл экспортолдог хүмүүсийн эсрэг чиглэсэн байна. Түүнчлэн дээр дурдсан металлуудыг олборлох, үйлдвэрлэхэд ашигладаг тоног төхөөрөмжүүдийг Иранд нийлүүлэхийг хоригложээ. Ираны эсрэг авсан шинэ хориг арга хэмжээ нь тус улсын экспортын 10 хувьд нөлөөлөх болно гэж Трамп мэдэгдэв.¹⁸

Сири: Сирид зэвсэгт сөргөлдөөн эхэлсэн 2011 оны 3 дугаар сараас хойш НҮБ-ын АЗ Дамаскийн эсрэг хориг арга хэмжээ авах тогтоолыг өнөөг хүргэл баталж чадаагүй нь Орос, Хятадын эсрэг байр суурьтай холбоотой. Гэсэн ч Дамаскийн эсрэг олон улсын хориг арга хэмжээг EX, Арабын орнуудын Лиги хэрэгжүүлж байгаа юм. Сөргөлдөөнтэй гурван жилийн дотор EX нь 19 удаагийн багц хориг тогтоож, түүнийхээ жагсаалтад 181 сирийн албан тушаалтан, 54 байгууллагыг хамруулсан байна. Хоригийн хар жагсаалтад нь Сирийн Ерөнхийлөгч Башар Ассад ба түүний гэр бүлийнхэн, олон тооны албан тушаалтан болон бизнесменүүд орсон байна. Тэднийг Европт оруулахыг хориглож, банкны дансуудыг нь Европын банкуудад битгүүмжилжээ. Европын хоригт Сирийн иргэний агаарын тээврийн Syrian Arab Airlines үндэсний компани, Төв банк, зарим экспортын компаниуд нь орсон байна. Сиритэй зэвсгийн болон нефть, нефтийн бүтээгдэхүүний худалдаа хийхийг хоригложээ. Арабын орнуудын Лигийн Зөвлөл 2011 оны 11 дүгээр сарын 27-нд Сирийн эсрэг авах хориг арга хэмжээгээ батлан удирдлагынх нь данснуудыг Арабын орнуудад битгүүмжилж, Сиритэй хамтарсан төсөл хэрэгжүүлэх мөн ажил хэргийн холбоо тогтоох зэрэгт хязгаарлалт хийсэн байна. Сирийн Нефтийн ба байгалийн баялгийн сайд Суфьян Аллаугийн хэлснээр 2011 оны 9 дүгээр сард Сирийн нефтийн импорт ба салбарын хөрөнгө оруулалтад европчуудын тавьсан хоригийн улмаас тус орон 4 тэрбум ам. долларын хохирол амссан байна. Сөргөлдөөн гаражын өмнө Сирийн ДНБ-ий хэмжээ нь 2010 оны мэдээгээр, 59.33 тэрбум ам. долларт хүрч байсан ажээ. 2014 он гэхэд Сирийн ДНБ-ий үйлдвэрлэл 35 хувиар буурчээ. Сирийн нефтийг худалдан авахад EX-ны тавьсан хориг тус орны ашгийг 25 хувиар унагасан байна. Сүүлийн үед ОХУ Дамасакийн эрх баригчдыг дэмжиж, орчин зэвсэг техник нийлүүлж байгаа нь Сирийн иргэний дайны хор уршгийг өргөжүүлж, хугацааг нь уртасгах төлөвтэй болгож байгаа нь ажиглагдаж

¹⁸ “Donald Trump announces new sanctions against Iran amid nuclear tensions”- Thursday 9 May 2019
<https://news.sky.com/story/donald-trump-announces-new-sanctions-against-iran-amid-nuclear-tensions-11714851>

байна гэж өрнөдийн олон улсын тоймчид бичиж байгаа юм.

Венесуэл: АНУ Венесуэлийн эсрэг 2017 оноос эдийн засгийн хориг арга хэмжээ авч хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд тухайн онд 6 удаа, 2018 онд 7 удаа, 2019 он гараад 5 дугаар сарын 22-ны байдлаар 30 удаагийн арга хэмжээнд 150 гаруй компани, Н.Мадурог тойрон хүрээлэгч 720 хүнд хориг тавьчихаад байна. Хоригийн зорилго нь Николас Мадурог огцруулж, ерөнхийлөгчийн шударга сонгууль явуулах, хүний эрх, эрх чөлөө, ардчилал, сайн засаглал, зах зээлийн харилцааг сэргээх зорилготой ажээ.

2019 оны 4 дүгээр сарын 17-нд Куба, Венесуэл, Никарагуа улсын эсрэг АНУ шинэ хориг арга хэмжээ авсан тухай тус улсын Сангийн яам мэдэгдсэн билээ. Хориг арга хэмжээнд Венесуэлийн Төв банк, Никарагуагийн “Corporativo” банк орсон байна. Түүнчлэн Никарагуагийн Төрийн тэргүүн Даниэль Ортегагийн хүү Ортега Мурильо болон Венесуэлийн Төв банкны тэргүүн Рузза Теран нар хориг арга хэмжээний жагсаалтад багтжээ. Мөн Кубын тагнуулын албатай холбоотой 5 байгууллагын эсрэг АНУ хориг арга хэмжээ авсан байна. АНУ-ын Ерөнхийлөгчийн Үндэсний аюулгүй байдлын асуудал эрхэлсэн зөвлөх Жон Болтоны мэдэгдсэнээр Кубын агаарын тээврийн “Aerogaviota” компани хориг арга хэмжээнд багтсан байна. Түүнчлэн Кубад төрөл садан нь байдаггүй Америкийн иргэдийг Куба улсад зорчих эрхийг хориглосон байна.

Венесуэлийн Ерөнхийлөгч Николас Мадурог дэмжих нь хууль бус, мөн хүний эрхийг зөрчиж байна гэж Кубын эрх баригчдыг буруутгаж байгаатай холбогдуулан энэхүү хориг арга хэмжээг авчээ.

Венесуэлийн эрх баригчид АНУ-ын авсан хориг арга хэмжээнүүдийг тойрон гарахын тулд Оросын «Роснефть» компанийн үйлчилгээг ашиглаж байна. Оросын «Роснефть» компани нь Венесуэлийн төрийн өмчит газрын тос, хийн “PDVSA” компани болон тус улсын газрын тосыг эцсийн худалдан авагчийн хооронд зууч нь болж байгаа аж. Орос болон Венесуэлийн талаас энэ талаар албан ёсоор тайлбар өгөөгүй байгаа талаар “Reuters” агентлаг мэдээлсэн байна.¹⁹

АНУ Венесуэлийн эсрэг авсан хориг арга хэмжээгээ 4 дүгээр сарын 12-нд чангатгаж, 4 компанийг хар жагсаалтад оруулсан юм. Өмнө нь Венесуэлийн газрын тосны салбарт ажилладаг байсан хоёр компанийг хориг арга хэмжээний жагсаалтад оруулсан. Хориг арга хэмжээнд орсноор АНУ дахь хөрөнгийг нь царцааж, америкийн иргэд болон компаниудыг хоригт багтсан хувь хүн болон компанитай бизнес эрхлэхийг хориглож байгаа юм.

АНУ Куба улсын эсрэг шинэ хориг арга хэмжээ авах бодолтой байгаагийнх нь хариуд компаниудынхаа ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд бэлэн байгаагаа EX АНУ-д анхааруулжээ.

¹⁹ Exclusive: After U.S. sanctions, Venezuela seeks to collect some oil payments via Rosneft. April 18, 2019 <https://www.reuters.com/article/us-venezuela-politics-rosneft-exclusive/exclusive-after-us-sanctions-venezuela-seeks-to-collect-some-oil-payments-via-rosneft-idUSKCN1RU2A4>

Энэ тухай ЕХ-ны Гадаад бодлого, аюулгүй байдлын асуудал эрхэлсэн дээд комисsar Федерика Могерини болон Худалдааны асуудал эрхэлсэн Европын комисsar Сесилия Мальмстрем нарын 4 дүгээр сард АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Майк Помпеод илгээсэн захидалд дурджээ. Албан эх сурвалжийн мэдээлснээр, Куба, Венесуэл, Никарагуа улсын эсрэг шинэ хориг арга хэмжээ авах тухайгаа АНУ зарлах бодолтой байгаа аж. АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трампын Засаг захиргаа Куба улсад бизнес эрхэлж буй гадаадын компаниудын эсрэг шүүхэд гомдол гаргахыг зөвшөөрөх бодолтой байгаа ажээ. Ф.Могерини, С.Мальмстрем нар захидалдаа, АНУ болон ЕХ-ны 1998 онд байгуулсан хэлэлцээрийг дагаж мөрдөхийг М.Помпеогоос шаарджээ. Хэлэлцээрт Европын компаниудын халдашгүй байдлыг тусгасан байдаг байна. “Хэлэлцээрийг дагаж мөрдөхгүй бол ЕХ ашиг сонирхлоо хамгаалахын тулд олон улсын бусад түнштгэйгээ хамтран ажиллах бүхий л арга хэрэгслээ ашиглах шаардлагатай болно” хэмээн тус захидалд дурдсан байна.

Америкийн шүүхээс гаргасан шийдвэрийн үр дүнд учирч болзошгүй хохирлыг нөхөн төлүүлэх тухай сөрөг гомдлыг Европын компаниуд ЕХ-ны гишүүн орнуудын шүүхэд гаргаж магадгүй болохыг тус холбооны төлөөлөгчид М.Помпеод анхааруулж байгаа ажээ.²⁰

Венесуэлийн эсрэг авсан хориг арга хэмжээг чангатгах, тус улсын оршин суугчдад 400 сая ам.долларын хүмүүнлэгийн тусламж олгоход чиглэсэн хуулийн төслийг Конгрессын Сенатын танхимиын Гадаад хэрэг эрхэлсэн Хороо 2019 оны 5 дугаар сарын 22-ны лхагва гарагт баталжээ. Энэ тухай Ардчилсан намын гишүүн Роберт Менендес мэдэгдсэн байна.

“Энэхүү хуулийн төсөл нь хүмүүнлэгийн тусламжийн хэмжээг нэмэгдүүлж, улс оронд ардчиллыг сэргээж, хөгжил цэцэглэлт авчрах Венесуэлийн түр Ерөнхийлөгч Хуан Гуайдогийн хүчин чармайлтыг дэмжин хүлээн зөвшөөрч, Николас Мадурогүйгээр улс орныг сэргээх төлөвлөлтийн үйл явцыг олон улсын санхүүгийн байгууллагуудтай хамтран хурдасгахад тус дөхөм болох юм” хэмээн тэрбээр хэлсэн байна. Хоёр намын хууль тогтоогчдын дэмжиж буй санаачилга нь хориг арга хэмжээнд багтаж буй албан тушаалтнуудын гэр бүлийн гишүүдэд визийн шинэ хязгаарлалтыг нэвтрүүлэх, хүмүүнлэгийн хямралтай холбоогүй, Х.Гуайдог төрийн тэргүүнээр хүлээн зөвшөөрч байгаа хүмүүсийг хар жагсаалтаас хасахыг уриалжээ.²¹

Хориг ба Монгол Улсын сорилт

Далай ламын айлчлалын үр дагвар: 2016 оны 11 дүгээр сард Дээрхийн гэгээн

²⁰ Brussels warns U.S. against exposing EU firms in Cuba to claims. April 16, 2019
<https://www.cnbc.com/2019/04/16/reuters-america-brussels-warns-u-s-against-exposing-eu-firms-in-cuba-to-claims.html>

²¹ Senate Committee Approves Comprehensive Legislation to Help Restore Democracy in Venezuela. US Senate Committee on Foreign Relations May 22, 2019 <https://www.foreign.senate.gov/press/release/senate-committee-approves-comprehensive-legislation-to-help-restore-democracy-in-venezuela>

XIV Далай лам Бурхан шашинтны төв Гандантэгчлэн хийдийн урилгаар Монгол Улсад есдэх удаагийн айлчлалаа хийж сүсэгтэн олон, лам хуваргуудаа ном айлдсан нь Монгол, Хятадын харилцаанд ноцтой асуудал үүсгэв. Монгол Улсад хийсэн Далай ламын айлчлал дөрвөн хоног үргэлжилсэн бөгөөд айлчлалын хүрээнд Буянт-Ухаа спорт цогцолборт сүсэгтэн олонд зориулан Богд ламын ван авшиг, Шар жигжид бурханы насны авшиг, Жанрайсиг бурханы авшиг, Цагаан дарь эхийн насны авшиг “Шүтэн барилдлагын магтаал”, “Мөрийн гурван эрхэм” зэрэг нэн ховор ном айлдажээ.

Айлгальын эхэнд Дээрхийн Гэгээн XIV Далай лам “Монгол Улсын Ерөнхийлөгч тэргүүний шашны хүмүүс, Монголын бурхны шашинт төв Гандантэгчилэн хийд Хамба лам тэргүүтэй сүсэгтэн олныхоо хүсэл зорилгоор ирж та бүхэнтэйгээ мэндчилж байна” гэсэн нь анхаарал татжээ. Тэрбээр өгүүлэхдээ: “Би өндөр хөгжилтэй олон оронд очсон. Гадна талын хөгжил бол хүний таван мэдрэхүйг амгалан байлгадаг хэдий ч дотоод сэтгэлийг амгалан байлгаж чадахгүй. Дотоод сэтгэл амгалан байх нь бүхий л зүйл хийгээд эрүүл мэндэд ч тустай” хэмээсэн юм. Соёлын төв өргөөнд лам хуврагууд болон их, дээд сургуулийн эрдэмтдийн дунд зохион байгуусан “Шинжлэх ухаан ба бурханы сургаал” сэдэвт хэлэлцүүлэгт оролцож сургааль номоо айлдав. Мөн оюутан залуусын төлөөлөлтэй Соёлын Төв Өргөөнд уулзаж “Шинэ Мянганы ёс суртахуун ба буддизм” сэдэвт уулзалтад оролцож, нийт 1300 оюутан залууст зориулан хувь хүний ёс суртахуун, үнэлэмжийн талаар ном айлдаж, тэдний сонирхсон асуултад хариулсан байна. XIV Далай лам Данзанжамц Монгол Улсад айлчлахаар ирсэн нь бүс нутгийн буддын шашинт орууудын сүсэгтнуүдийг Монгол руу татжээ. Энэ арга хэмжээнд адис хүртэхээр ОХУ-ын Буриадаас 40 гаруй лам нарын бүрэлдэхүүнтэй баг Улаанбаатарт хүрэлцэн иржээ. Монголд анх удаа зохион байгуулагдсан “Mind and Life” буюу “Оюун санаа ба амьдрал” олон улсын эрдэм шинжилгээний 31 дэх удаагийн хэлэлцүүлэг “Corporate convention center”-т болж Дээрхийн Гэгээнтэн XIV Далай лам мөн оролцсон байна.

Гэвч Далай ламын айлчлалтай холбогдуулан БНХАУ Монгол Улстай хийх хэд, хэдэн албаны уулзалтаяа цуцлаж буйгаа мэдэгдэж, түүгээр ч зогсохгүй хоёр орны төрийн харилцаанд сэв суулгасан тул даруй харилцаагаа эргэн хэвийн байдалд оруулахыг шаардсан мэдэгдлийг Хятадын ГХЯ-ны хэвлэлийн төлөөлөгч Гэн Шуан (Geng Shuang) хийсэн байна. Энэ асуудлаар Гадаад хэргийн сайд Ц.Мөнх-Оргил Монголын талын байр суурийг илэрхийлэхдээ: “Далай ламын Монгол Улсад хийсэн айлчлал улс төрийн агуулгагүй, зөвхөн Монголын сүсэгтэн олонд ном айлдсан гэдгийг тайлбарлаж, хойшилсон, цуцлагдсан айлчлал удахгүй зохих хугацааны дараа үргэлжилнэ гэж найдаж байгаагаа илэрхийлсэн. Мөн Далай багшийг урьж авчрахад ямар нэгэн төр, засгийн байгууллага албан тушаалтан оролцоогүй. Энэ бол Монголын бурхан шашинтны төв Гандантэгчлэн хийдийн тэргүүн Хамба лам Д.Чойжамц тэргүүтэй шашны байгууллагаас зохион байгуулсан айлчлал. Монгол Улсад төр, шашин тусдаа учраас энэ айлчлалыг зохион байгуулахад төр

оролцоогүй” гэжээ. Далай ламын айлчлалаас үүдэн Монгол Улс БНХАУ-аас зээл авах асуудлаар 2016 оны 11 дүгээр сарын 28-29-нд болох яриа хэлэлцээ мөн хойшилсон байна.

Түүнчлэн 12 дугаар сарын 5-нд Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргилын БНХАУ-д хийх айлчлал, 11 дүгээр сарын 23-25-ны өдрүүдэд УИХ, БНХАУ-ын парламентын зөвлөлдөх уулзалтад Монголын тал оролцох боломжгүй болов. Үүний зэрэгцээ 11 дүгээр сарын 28-29-ны өдөр Шадар сайд У.Хүрэлсүхээр ахлуулсан ажлын хэсэг БНХАУ-ын Хөгжил шинэчлэлийн хорооны даргаар ахлуулсан ажлын хэсгийнхэнтэй уулзаж, хөнгөлөлттэй зээл, Тавантолгойн төмөр зам, зэс хайлуулах үйлдвэр, нүүрснээс хий гаргах төслийн талаар ярилцахаар төлөвлөөд байсан ч эдгээр уулзалтуудыг цуцалснаа Хятадын тал мэдэгдэв. 12 дугаар сарын 5-7-ны өдрүүдэд Москва хотноо болох Ази-Номхон далайн улс орнуудын Зам тээврийн сайд нарын уулзалтын үеэр ОХУ, Монгол Улс, БНХАУ-ын Азийн хурдны замын сүлжээний дагуу олон улсын тээвэр хийх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрт гарын үсэг зурах асуудал ч аанай л цуцлагдах төлөвтэй болсон байна.

Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргил яаж ч тайлбарласан тодорхой баримт гарч ирсэн юм. Энэ нь Дээрхийн гэгээн XIV Далай лам Буянт-Ухаа спорт цогцолборт сүсэгтэн олонд зориулсан айлтгалын эхэнд: “Монгол Улсын Ерөнхийлөгч тэргүүний шашны хүмүүс, Монголын бурхны шашинт төв Гандантэгчилэн хийд Хамба лам тэргүүтэй сүсэгтэй олныхоо хүсэл зорилгоор ирж та бүхэнтэйгээ мэндчилж байна” гэж хэлжээ. Түүгээр ч зогсохгүй АНУ-аас Монголд суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Женнифер Зидмал Галт өөрийн twiiter-тээ тодорхой баримтыг дэлгэв. Тухайлбал:

Jennifer Z.Galt

@USAmbMongolia

МУ-д тэвчээр, итгэл, учирлалын тухай
сургаалаа түгээн явaa Дээрхийн гэгээн

@ DalaiLama-тай уулzsандаа баяртай байна.

@ elbegdorji-д баярлалаа.



10:44 pm – 21 Nov 2016²²

гэжээ. Энэ нь хөдөлшгүй баримт болов.

Далай ламын айлчлалын талаар Нью Йорк таймс сонин бичихдээ “Өнөөдрийг хүртэлх хугацаанд БНХАУ Далай ламын Монголд хийсэн айлчлалтай холбоотойгоор хоёр ч удаа хоёр улсын харилцаанд цав сууж байсан удаатай. Тухайлбал, 2002 онд хилээ хааж байсан бол 2006 онд Бээжингээс Улаанбаатар руу хийх нислэгийг цуцалж байсан юм. БНХАУ-ын хувьд Далай ламыг Түвдийг Хятадаас салан тусгаарлахыг эрмэлздэг тэрслүү этгээд гэж үздэг бөгөөд энэ үүднээс түүний аливаа улсад хийх айлчлалыг хүчтэй эсэргүүцсээр ирсэн байдаг. Далай лам 1959 онд Хятадын удирдлагыг эсэргүүцсэн бослогын үеэр Түвдийг орхисноос хойш эдүгээ Энэтхэгт амьдарч байна. Тэгвэл энэ удаагийн түүний Монголд хийх айлчлалтай холбоотойгоор Хятадын ГХЯ-наас мэдэгдэл хийж, хоёр улсын цаашдын харилцааны төлөө Далай ламын айлчлалыг цуцлахыг шаардсан. Учир нь Монголын эрх баригчид эдийн засгaa гүн хямрааас татаж гаргахын тулд Бээжингээс 4.2 тэрбум ам.долларын зээл авахыг эрэлхийлж байгаа юм. Өргөн хэрэглээний барааны үнэ унасан, гадаадын өрөө эргэн төлөх хүндхэн нөхцөл байдалд буй Монгол Улс экспортын 90 орчим хувийг эзлэх Хятадаас тусlamж авах гаргалгааг хайж байгаа билээ” гэсэн байна.²³

Харин *tibet.net* цахим хуудсанд бичихдээ: Хятадыг тайван замаар ардчилсан засаглалд шилжүүлэхийн төлөө тэмцдэг “Хятадын санаачилга” (Initiative for China-IFC) хөдөлгөөн 2016 оны 11 дүгээр сарын 28-нд мэдэгдэл гаргаж Коммунист Хятадын дарамт шахалтыг үл тоон Далай ламын шашин номын айлчлалыг зөвшөөрсөн Монголын эрх баригчдын зүрх зоригийг магтан

²² <https://twitter.com/USAmbMongolia/status/800952963967565824>

²³ Dalai Lama’s Visit to Mongolia Could Fray Its Ties to China. New York Times. Nov.19, 2016 <https://www.nytimes.com/2016/11/20/world/asia/mongolia-dalai-lama-china.html>

сайшаажээ. Мэдэгдэлд Далай ламын Улаанбаатарт хийсэн айлчлалтай холбоотой Бээжингийн гаргасан мэдэгдэл, авсан арга хэмжээнүүдийг шүүмжилсэн байна. Мөн Тайвань, Өмнөд Африк зэрэг бусад орнуудыг Монголын жишгээр Хятадын дарамтаас айлгүйгээр Далай ламыг нутагтаяа хүлээж авахыг уриалжээ. АНУ-ын ерөнхийлөгчөөр сонгогдоод байгаа Дональд Трампиг Далай ламтай ойрын үед уулзахыг IFC бас уриалсан байна. Өнгөрсөн долоо хоногт Тувдийг дэмжигч олон улсын парламентчдын бүлэг (The International Network of Parliamentarians for Tibet) мөн мэдэгдэл гаргаж, Монголын үлгэр жишээг дагахыг Азийн Буддын шашинт орнуудад уриалсан байна. Тус бүлгийн тэргүүн, Европарламентын гишүүн Томас Манн (Thomas Mann) мэдэгдэлдээ: “Далай ламын шашин номын айлчлалыг зөвшөөрсөн Монголын Засгийн газрын шийдвэрийг бид алга ташин хүлээж авч байна” гэжээ.²⁴

Хятадын хоригтой холбогдуулан тухайн үед Монгол Улсаас БНЭУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Г.Ганболд тус улсын Ерөнхий сайд Нарендра Модигийн 2015 оны 5 дугаар сард Монгол Улсад хийсэн айлчлалын үеэр амласан 1 тэрбум ам. долларын зээлийг ажил хэрэг болгохоор идэвхтэй хөөцөлдөж байжээ. Элчин сайд Г.Ганболдын хүсэлтийг БНЭУ-ын ГХЯ ч нааштай хүлээн авч байгаагаа илэрхийлээд байжээ. Харин үүний дараахан Хятадын гадаад бодлогын тусгал болдог өдөр тутмын Global Times.cn албан ёсны цахим сонинд: “Монгол Улс салан тусгаарлагчийг хүлээж авсан үйлдэлдээ шүүмжлэлтэй хандах хэрэгтэй” гэсэн нийтлэл гарчээ. Түүнд: “Орос, Хятадын дунд оршдог Монгол Улс төвийг сахих байр суурь баримталж, аливаа их гүрнүүдийн сөргөлдөөнд хутгалдахгүй байх нь ашигтай” болохыг сануулж, “Монгол Улс Энэтхэгээс тусlamж хүссэн явдал нь улс төрийн хувьд гоомой шийдвэр бөгөөд ингэснээр байдлыг улам хүндрүүлж, асуудлыг шийдэх боломжийг улам багасгана” хэмээгээд “Хямралд автсан Монгол Улс алдаанаасаа суралцаасай гэж бид хүсэж байна”²⁵ гэж сургасан байна.

Хятадын төрийн мэдээллийн Синьхуа агентлаг оны төгсгөлд буюу 2016 оны 12 дугаар сарын 29-нд Монгол Улстай холбоотой нэгэн мэдээлэл гаргасан юм. Түүнд дурдсанаар 2016 оны сүүлийн хоёр долоо хоногт БНХАУ гадаад бодлогодоо “hat-trick” хийж, олон улсын тавцанд нэр хүндээ өргөж чадсанаа бахархалтайгаар мэдээлжээ.²⁶ “Hat-trick” гэж спортын өртөнцөд нэг тэмцээнээс гурван сайн үзүүлэлт, гурван оноо дараалан авах үзэгдлийг нэрлэдэг байна. БНХАУ 2016 оны сүүлийн хэд хоногт авсан “гурван оноогоор” Норвеги улстай харилцаагаа хэвийн болгосон, Монгол Улсаас Далай ламыг дахин хүлээж авахгүй гэсэн амлалт авсан, Сан Томе ба Принсиби улс Тайваниас дипломат харилцаагаа тасалж, Бээжинтэй харилцаагаа сэргээсэн зэрэг гурван үйл явдлыг нэрлэжээ.

Эдгээр үйл явдлууд нь Хятадын дипломат бодлого хэрхэн хүчирхэгжиж байгааг дэлхий дахинд харуулж, Хятадын үндэсний ашиг сонирхлыг хүндэтгэх нь хий

²⁴ His Holiness the Dalai Lama Arrives to a Warm Welcome in Mongolia. November 19, 2016

<https://tibet.net/2016/11/his-holiness-the-dalai-lama-arrives-to-a-warm-welcome-in-mongolia/>

²⁵ <http://www.globaltimes.cn/content/1024836.shtml>

²⁶ China Voice: Diplomatic hat-trick no accident – Xinhuanet.com | English.news.cn Dec. 29, 2016

хоосон яриа төдий зүйл биш болохыг харууллаа гэж онцолсон байна.

2010 онд Норвеги улс Нобелийн Энхтайвны шагналыг Хятадын тэrs үзэлтэн зохиолч Лю Шяобод (Liu Xiaobo) олгосны дараа хоёр орны харилцаа зургаан жилийн туршид царцангы байдалд орсон юм. Тэгвэл саяхан Норвеги улс “нэг Хятад” бодлогыг хүндлэхээ амласнаар харилцаа эргэн хэвийн болсон байна.

Үүний нэгэн адил Монгол Улс Түүдийн шашны тэргүүн Далай ламыг хүлээж авснаасаа хойш нэг сарын дараа дахин түүнийг нутагтаа хүлээж авахгүй гэдгээ амласнаар хэсэг хугацаанд муудаад байсан эдийн засгийн харилцаа сэргэх замдаа орлоо гэжээ. Гурав дахь жишээ болсон Африкийн Сан Томе ба Принсиби улс анх 1975 онд Хятадтай дипломат харилцаа тогтоож байсан боловч 1997 онд санхүүгийн дэмжлэг авах сонирхлоор Тайваньтай дипломат харилцаа тогтоож, эх газрын Хятадыг орхиж байжээ. Тэгвэл Тайваний тусlamжинд сэтгэл дундуур байсан 200 мянган хүн амтай арал улс хэдхэн хоногийн өмнө Тайваниас салж, Бээжинтэй дипломат харилцаагаа эргэн сэргээсэн байна гэж бичсэн байна.

2017 оны 1 дүгээр сарын 24-нд Монгол Улсын Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргил БНХАУ-ын Гадаад хэргийн сайд Ван Ий-тэй утсаар ярихдаа: “Монгол Улс нь “Нэг Хятад”-ын уламжлалт бодлогыг тууштай баримталдаг. Түүд нь Хятадын салшгүй нэг хэсэг бөгөөд Түүдийн асуудал Хятадын дотоод хэрэг гэж үзсээр ирсэн бөгөөд бие биеийнхээ язгуур ашиг сонирхлыг хүндэтгэх нь хоёр талын харилцааны хөгжлийн суурь зарчим гэж үзэж байна. Гандантэгчэнлин хийдийн урилгаар Далай ламын Монголд хийсэн айлчлал Монгол, Хятадын найрсаг харилцаанд сөрөг нөлөө үзүүлсэнд Монгол Улсын Засгийн газар харамсч байна. Түүнчлэн Далай ламын айлчлал болон Х Богдыг тодруулах асуудлаар өмнө нь олон нийтэд Монголын хэвлэлээр мэдэгдсэн байр сууриа дахин илэрхийлж, Монголын тал БНХАУ-тай найрсаг харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд өндөр ач холбогдол өгдөг” хэмээжээ.²⁷

Хариуд нь БНХАУ-ын Гадаад хэргийн сайд Ван Ий “Хятад, Монголын харилцааг тогтвортой хөгжүүлэх нь хоёр улс болон хоёр улсын ард түмний язгуур эрх ашигт нийцнэ. Монголын талын өмнө нь хэвлэл, мэдээллээр нээлттэй мэдээлсэн байр суурь, ялангуяа энэ Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанд **Далай ламыг айлчлуулахгүй байх тухай тодорхой амлалт өгснийг хятадын тал анхааралдаа авсан**. Цаашид Монголын тал хоёр улсын харилцааны хөгжлийн төлөө Хятадын талын язгуур эрх ашигийг хүндэтгэн, Хятад, Монголын харилцаанд бий болсон сөрөг нөлөөг арилгахад бодитой хүчин чармайлт гаргаж буйд баяртай байна” гэжээ. Тэд ярианыхаа төгсгөлд Монгол, Хятадын Иж бүрэн стратегийн түншлэлийн хүрээнд харилцан ашигтай хамтын ажиллагааг үргэлжлүүлэн хөгжүүлэхэд хүчин чармайлт гарган, хамтран ажиллахaa илэрхийлцгээсэн байна.

Далай ламыг ОХУ-д нэвтрэхийг хориглоогүй гэж тус улсын Ерөнхийлөгч

²⁷ Ван Ий: Далай ламыг айлчлуулахгүй байх амлалт өгснийг Хятадын тал анхааралдаа авсан <http://eagle.mn/r/23475>

Владимир Путин “Бүх Оросын ардын фронт” нийгэм-улс төрийн байгууллагуудын эвслийн медиа форумын үеэр мэдэгдсэн байна. Уг медиа форумд оролцогчдоос Далай лам ойрын үед ОХУ-д айлчлах боломжтой юу? гэж Путинээс асуужээ. “Далай ламыг Орост нэвтрэхийг бид хориглодоггүй. Гэхдээ манай улсад амьдарч буй буддын шашинтнууд тийм ч олон биш. Бид христийн шашинтнууд, иудейчүүд, лалын шашны төлөөлөгчдөд бүгдэд нь адил тэгш ханддаг” гэж Путин хэлсэн байна. “Энэ сэдвээр бид тусдаа ярилцана. Буддын шашин шүтдэг маш олон иргэнтэй улс орнууд бий боловч тэдний Далай ламтай хийж буй харилцаа тийм ч сайн биш. Гэсэн хэдий ч бид бодож үзнэ” гэж тэрбээр нэмж хэлжээ. Түүдийн бурхан шашны тэргүүний үйл ажиллагаанд “улс төрийн сиймхий” байdag учраас Далай лам ОХУ-д айлчлах боломжгүй гэж үзэж байгаагаа тус улсын ГХЯ урьд нь мэдэгдсэн байна.²⁸

ЕХ-ны сануулга: ЕХ түүхэндээ анх удаа оффшор бүсүүдийн нээсийг багтаасан хар жагсаалтыг 2017 оны 12 дугаар сарын 5-нд зарласан билээ.²⁹ Дурдсан хар жагсаалтад 17 орон багтсаны дотор Монгол Улс багтсан юм. Panama Papers, Paradise Papers зэрэг нууц мэдээллүүд ил болж, тус холбооны гишүүн орнуудын компани, хувь хүмүүс татвараас зайлсхийж байсан нь илэрсэн тул ийм арга хэмжээ авчээ. Хар жагсаалтад Америкийн Самоа, Бахрейн, Барбадос, Гренада, Гуам, Өмнөд Солонгос, Макао, Маршаллын арлууд, Монгол, Намиби, Палау, Панам, Сэйнт Лусиа, Самоа, Тринидад ба Тобаго, Тунис, АНЭУ зэрэг орнуудыг оруулсан байна. Эдгээр орнуудыг хар жагсаалтад оруулахдаа тухайн улсын татварын орчны ил тод байдал, татварын хувь хэмжээ нь гадны этгээдүүдийн сонирхлыг татах чадвартай эсэх зэргээр нь үнэлжээ. Мөн ЕХ-ны татварын стандарттай хэр зэрэг нийцэх нөхцлийг харж үзсэн ажээ.

Хар жагсаалтад орсон орнууд юуны өмнө Европын санхүүгийн зах зээлд хандах эрхгүй болохоор байв. Мөн энэ удаа 47 орныг багтаасан “watchlist” буюу Европын татварын стандартыг удахгүй дагах амлалт өгөөд байгаа орнуудын *саарал* (grey) жагсаалтыг мөн гаргажээ.³⁰ Эдгээр орнуудыг татварын системдээ өөрчлөлт хийх явцыг хэсэг хугацаанд харзнах ба өөрчлөлт хийж чадвал жагсаалтаас гаргаж, чадахгүй бол хар жагсаалт руу шилжүүлэхээр заажээ. Далайн хар салхины гамшигт өртсөн Карибын тэнгисийн сав газрын зарим орнуудыг энэ удаа хар жагсаалтад оруулахыг хойшлуулснаа ЕХ мөн тэмдэглэсэн юм. Монгол Улс хар жагсаалтад орсноор тодорхой эрсдэлүүдтэй тулгарсан. Энэ бол анхааруулгын арга хэмжээ байсан хэдий ч таатай зүйл биш байв.

2017 оны 6 дугаар сараас эхлэн ЕХ Монгол Улсын Сангийн яамтай дурдсан асуудлаар харилцаж эхэлсэн байх бөгөөд Монгол Улс ил тод байх зарчмыг хууль тогтоомждоо тусгах шаардлагатай гэж тус холбоо үзэж байгаа талаараа өмнө нь танилцуулж байсан байна. Учир нь ЕХ-ны тавьж буй шаардлагад бусад орны иргэд

²⁸ ТАСС: В.Путин: далай-ламе въезд в Россию не запрещен. 16 Май, 2019 <https://tass.ru/obschestvo/6438635>

²⁹ Council conclusions on the EU list of non-cooperative jurisdictions for tax purposes.

<https://www.consilium.europa.eu/media/31945/st15429en17.pdf>

³⁰ New EU tax blacklist and grey list – here's what you need to know. Dec.6, 2017

<https://www.riskscreen.com/kyc360/article/new-eu-tax-blacklist-grey-list-heres-need-know/>

Монголын ААН, арилжааны банкуудад ямар хувь эзэмшиж байгаа болон ямар данс эзэмшиж байгаа зэрэг мэдээлэл ил тод байх ёстой гэсэн шаардлагыг тавьж байжээ. Θөрөөр хэлбэл, гадны улсын иргэдийн татвар, арилжааны банкуудын дансны мэдээлэл ил байх, мэдээллийг нээлттэй солилцдог байх ёстой гэсэн байр сууриа илэрхийлсэн байна. Энэ талаар хууль эрхзүйн зохицуулалт хийх ажлыг Сангийн яам зохион байгуулахаар ажилласан байна. Мөн Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-ын Глобал форум болон BEPS-ийн хөтөлбөрт гишүүнээр нэгдэхийн зайлшгүй чухлыг санал болгож байжээ.

Тийнхүү Глобал форум буюу “Татварын ил тод байдал, мэдээлэл солилцооны Дэлхийн форум” (The Global Forum on Transparency and Exchange of Information for Tax Purposes)-аас 2018 оны 1 дүгээр сарын 12-нд Монгол Улсыг 148 дахь гишүүн орноор бүртгэн авсан тухай албан бичгийг ирүүлсэн байна. Глобал форум нь 2000 онд 8-ын санаачилгаар үндэс суурь нь тавигдсан бөгөөд OECD-ын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг, OECD-ын гишүүд, харилцаач улсуудтай татварын ил тод мэдээлэл солилцох зорилготой байгууллага ажээ. Монгол Улс мөн хугацаанд BEPS (Base erosion and profit shifting) буюу “Татварын суурийг багасгах замаар ашиг зувчуулахын эсрэг хөтөлбөр”-ийн 111 дэх гишүүнээр элсчээ. BEPS нь 2012 онд 20-ын бүлгийн санаачилгаар OECD-ын хүрээнд байгуулагдсан байна.

EX-ноос татварын талаар хамтран ажилладаггүй 17 улсыг хар жагсаалтад оруулсан гол шалтгаан нь Монгол Улс “Татварын ил тод байдал, мэдээлэл солилцооны Глобал форум”-ын гишүүнээр элсээгүй, холбогдох хэлэлцээрт гарын үсэг зурж, соёрхон батлаагүй, “Татварын суурийг багасгаж, ашиг зувчуулахын эсрэг” заавал дагаж мөрдөх шалгуур үзүүлэлтийг хэрэгжүүлээгүйтэй холбоотой байв. Цаашид Монгол дахь гадаад иргэдийн данс, татварын мэдээллийг бусад орнуудтай нээлттэй солилцдог болох ёстой болж байна.

2018 оны 1 дүгээр сарын 18-нд Брюссель хотноо EX-ны гишүүн орнуудын элчин сайд нарын уулзалт болж, Монгол Улсыг оролцуулаад 8 улсыг жагсаалтаас гаргах нь зөв гэсэн шийдвэлд хүрч, 1 дүгээр сарын 23-нд Брюссель хотноо болсон EX-ны Сангийн сайд нарын Зөвлөлийн уулзалт EX-той татварын асуудлаар хамтран ажиллахаа амласан 8 улс орныг “татвараас зайлсхийгчдэд ээлтэй орнуудын хар жагсаалт”-аас хасав. Монгол, Өмнөд Солонгос, АНЭУ, Барбадос, Панам, Гренада, Макао болон Тунис зэрэг улсууд нь тодорхой хяналт шалгалт дор байх шаардлагатай улсуудын жагсаалт буюу **“саарал жагсаалт”** руу шилжсэн байна.³¹ Монгол Улсын Засгийн газар 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 350 дугаар тогтоол баталж татварын асуудлаарх сайн засаглалын зарчмуудыг хоёр жилийн хугацаанд хэрэгжүүлэх үүргийг EX-ны өмнө хүлээж, ОУХХАБ (OECD)-ын холбогдох байгууллагуудад гишүүнээр элсэх үндсэн дээр хар жагсаалтаас гарсан ажээ.

Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар дурдсан асуудлыг нэн даруй

³¹ <http://www.consilium.europa.eu/en/press/press-releases/2018/01/23/taxation-eight-jurisdictions-removed-from-eu-list/>

шийдвэрлэхийн тулд Тусгай үүрэг гүйцэтгэгч элчин сайд томилох, Сангийн яам болон ХЗДХЯ-ны төлөөллийг багтаасан Ажлын хэсэг байгуулан ажиллуулах, тэрчлэн ЕХ-ны Дээд төлөөлөгч бөгөөд Еврокомиссын Дээд Ерөнхийлөгч Ф.Могерини болон ЕХ-ны гишүүн 28 улсын Гадаад хэргийн сайд нарт албан захидал илгээх, ЕХ-ны гишүүн улсын элчин сайд нартай уулзаж Монгол Улсын байр суурийг тайлбарлах зэрэг дэс дараатай арга хэмжээ авсан нь ийнхүү нааштай үр дүнд хүрсэн гэж тэмдэглэсэн байна.³²

Монгол Улсын чухаг “гуравдагч хөрш” ЕХ, түүний гишүүн 28 оронтой Монгол Улс түншлэл, хамтын ажиллагаагаа цаашид өргөжүүлэн хөгжүүлэхэд тийнхүү тодорхой саад бэрхшээл үгүй болов.

ДҮГНЭЛТ

Эцэст нь эдийн засгийн хориг арга хэмжээ нь эрх баригчдын буруутай үйлдэлд нөлөөлөхөөсөө илүүтэй хүн ардад нь илүү сөрөг нөлөө үзүүлсээр байна. Түүнчлэн ОХУ-ын эсрэг авсан эдийн засгийн хориг эцэстээ олон улсын аюулгүй байдалд ноцтой сөрөг үр дагаварыг буй болгож шинэ хүйтэн дайны эхлэлийг тавьсан гэж үзэж болохоор байдаг. Хятад, Америкийн худалдааны дайны шинэ үе шат Монгол Улсын эдийн засаг, экспортод нөлөө үзүүлэх нь ойлгомжтой төдийгүй глобал худалдааны системд ноцтой сөрөг нөлөө үзүүлж болзошгүй байна.

Монгол Улс ч хариуцлагатай байж, гадаад бодлогын шийдвэр гаргалтад шинжлэх ухаанч, тооцоо, судалгаа, дүн шинжилгээ, эрсдлийн үнэлгээтэй хандаж, нэгдмэл байдлыг хадгалж, залгамж чанарыг хангах явдал чухал болсоор байгаа болно.

³² Монгол Улсыг ЕХ-ны татварын асуудлаар хамтран ажилладаггүй орнуудын жагсаалтаас хасав.
2018.01.23 <http://www.montsame.mn>

НОМ ЗҮЙ

1. Neutrality Acts of the United States 1930s <https://history.state.gov/milestones/1921-1936/neutrality-acts>
2. Mastanduno, M. *Economic containment: CoCom and the politics of East-West trade.* Cornell paperbacks. Cornell University Press, Ithaca, N.Y.: 1992,
3. Caraccioli, Tom. *Boycott: Stolen Dream of the 1980 Moscow Olympic Games.* Washington D.C.: New Chapter Press. 2008,
4. М.С.Горбачёв. Бүх юм өөрийн цаг хугацаатай. УБ.: 2013,
5. UN General Assembly Resolution 68/262. A/RES/68/262. 69th Plenary. 27 March 2014
6. The US keeps warning Turkey that buying Russia's S-400 missile system means it can't have the F-35, but Turkey keeps doubling down. Apr. 10, 2019
<https://www.businessinsider.com/us-congressional-committee-leaders-warn-turkey-on-f-35-s-400-2019-4>
7. Foreign Policy site. U.S. Senate Threatens Sanctions Over Russian Pipeline. May 13, 2019 <https://foreignpolicy.com/2019/05/13/us-senate-threatens-sanctions-over-russian-pipeline-nord-stream-two-geopolitics-energy-germany-europe-gazprom/>
8. U.S. Sanctions Russian Arms Makers Over Alleged Iran, N. Korea and Syria Dealings. <https://www.themoscowtimes.com/2019/05/22/us-sanctions-russian-arms-makers-over-alleged-iran-n-korea-and-syria-dealings-a65685>
9. N. Anguelov. Economic Sanctions vs. Soft Power: Lessons from North Korea, Myanmar, and the Middle East Palgrave Macmillan; 2015,
10. Ж.Бор. Д.Уламбаяр. Монголын дипломатын нэвтрэхий толь бичиг. С-Я Гутгаар боть. УБ., 2016,
11. United Nations Security Council resolution S/RES825 March 11, 1993
12. UN Security Council approves new North Korea sanctions. Sept. 11, 2017
13. Mattew Cooper. Mnuchin Threat to China Over North Korea is Empty Because Beijing Owns America's Debt. Newsweek. Sept. 12, 2017
14. Jesse Johnson, Reiji Yoshida. North Korea responds to latest U.N. sanctions with second missile over Japan. The Japan Times. Sept. 15, 2017
15. Voice of America.VOA, August 4, 2016, KoreajoongAngdaily.joins.com
16. “Donald Trump announces new sanctions against Iran amid nuclear tensions”- Thursday 9 May 2019. <https://news.sky.com/story/donald-trump-announces-new-sanctions-against-iran-amid-nuclear-tensions-11714851>
17. Exclusive: After U.S. sanctions, Venezuela seeks to collect some oil payments via Rosneft. April 18, 2019 <https://www.reuters.com/article/us-venezuela-politics-rosneft-exclusive/exclusive-after-us-sanctions-venezuela-seeks-to-collect-some-oil-payments-via-rosneft-idUSKCN1RU2A4>
18. Brussels warns U.S. against exposing EU firms in Cuba to claims. April 16, 2019 <https://www.cnbc.com/2019/04/16/reuters-america-brussels-warns-u-s-against-exposing-eu-firms-in-cuba-to-claims.html>
19. Senate Committee Approves Comprehensive Legislation to Help Restore Democracy in Venezuela. US Senate Committee on Foreign Relations May 22, 2019 <https://www.foreign.senate.gov/press/ranking/release/senate-committee-approves-comprehensive-legislation-to-help-restore-democracy-in-venezuela>
20. <https://twitter.com/USAmbMongolia/status/800952963967565824>

21. Dalai Lama’s Visit to Mongolia Could Fray Its Ties to China. New York Times. Nov.19, 2016. <https://www.nytimes.com/2016/11/20/world/asia/mongolia-dalai-lama-china.html>
22. His Holiness the Dalai Lama Arrives to a Warm Welcome in Mongolia. November 19, 2016. <https://tibet.net/2016/11/his-holiness-the-dalai-lama-arrives-to-a-warm>Welcome-in-mongolia/>
23. <http://www.globaltimes.cn/content/1024836.shtml>
24. China Voice: Diplomatic hat-trick no accident – Xinhuanet.com | English.news.cn Dec. 29, 2016
25. Ван Ий: Далай ламыг айлчлуулахгүй байх амлалт өгсний Хятадын тал анхааралдаа авсан <http://eagle.mn/r/23475>
26. TACC: В.Путин: далай-ламе въезд в Россию не запрещен. 16 Май, 2019 <https://tass.ru/obschestvo/6438635>
27. Counsil conclusions on the EU list of non-cooperative jurisdictions for tax purposes. <https://www.consilium.europa.eu/media/31945/st15429en17.pdf>
28. New EU tax blacklist and grey list – here’s what you need to know. Dec.6, 2017 <https://www.riskscreen.com/kyc360/article/new-eu-tax-blacklist-grey-list-heres-need-know/>
29. <http://www.consilium.europa.eu/en/press/press-releases/2018/01/23/taxation-eight-jurisdictions-removed-from-eu-list/>
30. Монгол Улсыг EX-ны татварын асуудлаар хамтран ажилладаггүй орнуудын жагсаалтаас хасав. 2018.01.23 <http://www.montsame.mn>

